



МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗАР

20 21 он 11
сарын 24 өдөр

Дугаар 37-1/138

Улаанбаатар
хот

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ДАРГА
Г.ЗАНДАНШАТАР ТАНАА

Хуулийн төсөл өргөн
мэдүүлэх тухай

Байгаль орчныг хамгаалах тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж, Монгол Улсын Их Хуралд өргөн мэдүүлж байна.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдаанаар хэлэлцүүлж өгнө үү.



Монгол Улсын Ерөнхий сайд

Л.ОЮУН-ЭРДЭНЭ

000021403980



МОНГОЛ УЛС
ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР

20 21 он 10 дугаар
сарын 07-ны өдөр

Дугаар Хэр/2397

Улаанбаатар-12
Утас: 260817
Факс: 976-11-310011

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ЕРӨНХИЙ НАРИЙН
БИЧГИЙН ДАРГА Л.ӨЛЗИЙСАЙХАН ТАНАА

Хуулийн төсөл өргөн мэдүүлэх
хугацааг товлох тухай

Байгаль орчныг хамгаалах тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхээр тогтсон тул холбогдох материалыг хүргүүлж байна.

Хянан үзэж, Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх хугацааг товлож өгөхийг хүсье.

Монгол Улсын сайд,
Засгийн газрын Хэрэг
эрхлэх газрын дарга



Ц.НЯМДОРЖ

000021512317

МОНГОЛ УЛСЫН ЗАСГИЙН ГАЗРЫН ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛЭЭС

Монгол Улсын Засгийн газрын 2021 оны 8 дугаар сарын 11-ний өдрийн хуралдааны 46 дугаар тэмдэглэлд:

“II.ХЭЛЭЛЦСЭН нь: Байгаль орчныг хамгаалах тухай хуульд нэмэлт оруулах хуулийн төсөл болон дагалдах хуулийн төсөл

ШИЙДВЭРЛЭСЭН нь: Монгол Улсын Их Хурлын 2020 оны 1 дүгээр сарын 9-ний өдрийн 02 дугаар тогтоолын дагуу Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөд хууль тогтоомжийг нийцүүлэх хүрээнд боловсруулсан “Байгаль орчныг хамгаалах тухай хуульд нэмэлт оруулах тухай” болон дагалдах хуулийн төслийг Засгийн газрын хуралдаанаар хэлэлцээд Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхээр тогтов.” гэжээ.



ЗАСГИЙН ГАЗРЫН ХЭРЭГ ЭРХЛЭХ ГАЗАР



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ ЗҮЙ,
ДОТООД ХЭРГИЙН САЙД

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Б.Ширэндэвийн гудамж 8/4, Засгийн газрын V байр,
Утас/Факс: (976-51) 26 75 33, И-мэйл: info@mojha.gov.mn,
Вэбсайт: www.mojha.gov.mn

2021.09.01 № 1/3760
танай 2021.08.23 -ны № 01/3799 -Т

БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ
ЖУУЛЧЛАЛЫН САЙД Н.УРТНАСАН
ТАНАА

Байгаль орчныг хамгаалах тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг Хууль тогтоомжийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.8 дахь хэсэгт заасны дагуу Монгол Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх нь зүйтэй гэж үзэв.



Х.НЯМБААТАР

151603889
А5 Файл 2021

11.11.20

11	9666	2021-09-03
	03	
	1	



МОНГОЛ УЛСЫН САНГИЙН САЙД

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
С.Данзангийн гудамж 5/1, Засгийн газрын II байр,
Утас/факс: (976-51) 26-74-68, <http://www.mof.gov.mn>

2021.08.31 № 6/4950

танай _____-ны № _____-т


БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН САЙД Н.УРТНАСАН ТАНАА

Байгаль орчныг хамгаалах тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийг Хууль тогтоомжийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.7 дахь хэсэгт заасныг үндэслэн Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх зөвшөөрөл олгож байна.


Б.ЖАВХЛАН

9764002900

9845
2021-09-02
14. 09.
1
E.



БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ

Нэг.Хуулийн төсөл боловсруулах үндэслэл, шаардлага

1.1.Хууль зүйн үндэслэл, шаардлага

Монгол Улсын Их Хурлаас 2019 оны 11 дүгээр сарын 14-ний өдөр Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулсан бөгөөд энэхүү нэмэлт, өөрчлөлтөөр Монгол Улсын Үндсэн хуулийн зургадугаар зүйлийн хоёр дахь хэсэгт "... Иргэн эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийнхээ хүрээнд газрын хэвлийн баялгийг ашигласнаар байгаль орчинд үзүүлэх нөлөөллийн талаар мэдэх эрхтэй ..." гэж тусгагдсан билээ.

Тус нэмэлт, өөрчлөлттэй холбогдуулан Монгол Улсын Их Хурал 2020 оны 1 дүгээр сарын 09-ний өдөр "Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөд хууль тогтоомжийг нийцүүлэх, түүнтэй холбогдуулан авах арга хэмжээний тухай" 2 дугаар тогтоолыг баталсан.

Засгийн газрын 2020 оны 2 дугаар сарын 19-ний өдрийн 66 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан "Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөд хууль тогтоомжийг нийцүүлэх ажлын төлөвлөгөө"-ний 3 дахь хэсэгт Монгол Улсын Үндсэн хуулийн зургадугаар зүйлд тусгагдсан, иргэний эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийнхээ хүрээнд газрын хэвлийн баялгийг ашигласнаар байгаль орчинд үзүүлэх нөлөөллийн талаар мэдэх эрхийг хангах талаарх зохицуулалтыг Байгаль орчныг хамгаалах тухай, Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуульд нэмэлт оруулахаар тусгасан.

1.2.Практик үндэслэл, шаардлага

Иргэн эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийнхээ хүрээнд газрын хэвлийн баялгийг ашигласнаар байгаль орчинд үзүүлэх нөлөөллийн талаар мэдэх эрхийг бататгах нь төрийн үндсэн үүрэг юм.

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль, Байгаль орчныг хамгаалах тухай хуулиар аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга нь тухайн орон нутагтаа байгаль орчны салбарын хууль тогтоомжийг хэрэгжүүлэх чиг үүргийг хэрэгжүүлдэг бөгөөд иргэдтэй хамгийн ойр харилцаж ажилладаг.

Иймд аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга иргэний мэдэх эрхийг хангах зохицуулалтыг Монгол Улсын Үндсэн хуульд орсон нэмэлт, өөрчлөлтийн хүрээнд Байгаль орчныг хамгаалах тухай хуульд оруулах шаардлага гарч байна.

Хоёр.Хуулийн төслийн ерөнхий бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээний талаар

Хуулийн төслийг Байгаль орчныг хамгаалах тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл хэлбэрээр боловсруулна.

Байгаль орчныг хамгаалах тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл нь 1 зүйл, 3 хэсгээс бүрдэнэ.

Байгаль орчныг хамгаалах тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөлд газрын хэвлийн баялгийг ашигласнаар байгаль орчинд үзүүлэх нөлөөллийн талаар иргэний мэдэх эрх болон иргэний тус эрхийг аймаг, нийслэл, сум дүүргийн Засаг дарга хангаж, иргэнд мэдээлэл өгөх асуудлыг тодорхой болгож тусгана.

Гурав.Хуулийн төсөл батлагдсаны дараа үүсч болох нийгэм, эдийн засаг, хууль зүйн үр дагавар, эдгээрийг шийдвэрлэх саналын талаар

Хуулийн төсөл батлагдсанаар Үндсэн хуульд заасан иргэний үндсэн эрхийг хамгаалах механизм бүрдэж, хууль тогтоомжийн хэрэгжилтийг хянах, мөрдүүлэх ажил сайжирч төр, иргэний харилцаанд дэвшил гарна.

Тус хуулийг баталснаар нийгэм, эдийн засаг, хууль зүйн сөрөг үр дагавар болон улсын төсөвт нэмэлт зардал үүсэхгүй.

Дөрөв.Хуулийг хэрэгжүүлэхтэй холбогдон цаашид шинээр боловсруулах буюу нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болгох хуулийн талаар

Энэхүү хуулийн төслийг Монгол Улсын Үндсэн хууль болон бусад хууль тогтоомжид нийцүүлэн боловсруулах бөгөөд хуулийн төсөлтэй холбоотойгоор Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл боловсруулна.

--- оОо ---

ТАНИЛЦУУЛГА

Байгаль орчныг хамгаалах тухай хуульд
нэмэлт оруулах тухай хуулийн төслийн тухай

Монгол Улсын Их Хурлаас 2019 оны 11 дүгээр сарын 14-ний өдөр Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулсан бөгөөд энэхүү нэмэлт, өөрчлөлтөөр Монгол Улсын Үндсэн хуулийн зургадугаар зүйлийн хоёр дахь хэсэгт "... Иргэн эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийнхээ хүрээнд газрын хэвлийн баялгийг ашигласнаар байгаль орчинд үзүүлэх нөлөөллийн талаар мэдэх эрхтэй ..." гэж хуульчилсан билээ.

Монгол Улсын Их Хурал 2020 оны 2 дугаар тогтоолоор баталсан "Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөд хууль тогтоомжийг нийцүүлэх, түүнтэй холбогдуулан авах арга хэмжээний хуваарь" болон Засгийн газрын 2020 оны 66 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан "Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөд хууль тогтоомжийг нийцүүлэх ажлын төлөвлөгөө"-ний 3 дахь хэсэгт иргэний энэхүү мэдэх эрхийг хангах асуудлыг Байгаль орчныг хамгаалах тухай, Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулан зохицуулахаар тусгасан.

Дээрх шийдвэрүүдэд нийцүүлэн хуулийн төслүүдийг боловсруулсан болно.

Үүнд: 1. Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 4 дүгээр зүйл буюу Байгаль орчныг хамгаалах талаарх иргэний эрх, үүрэг гэсэн хэсэгт "тухайн нутаг дэвсгэрийн хүрээнд газрын хэвлийн баялгийн ашиглалтын нөхцөл байдал, байгаль орчинд үзүүлж байгаа нөлөөлөл, нөхөн сэргээлт болон эрх бүхий байгууллагаас хяналтын чиглэлээр хэрэгжүүлж байгаа арга хэмжээний талаар мэдэх" эрхийг хангасан заалтыг нэмэв.

Мөн хуулийн 16, 17 дугаар зүйлд заасан аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын болон Засаг даргын бүрэн эрх гэсэн хэсэгт "харьяа нутаг дэвсгэрийн хүрээнд газрын хэвлийн баялгийг ашиглалтын нөхцөл байдал, байгаль орчинд үзүүлж байгаа нөлөөлөл, нөхөн сэргээлт болон хяналтын чиглэлээр хэрэгжүүлсэн арга хэмжээний талаар иргэдэд нээлттэй мэдээлэх, байгаль орчны төлөв байдлын мэдээлэлд тусгаж, иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд тайлагнах." гэсэн үүрэгжүүлсэн заалтыг нэмлээ.

2. Хуулийн төслийн үзэл баримтлалын дагуу Байгаль орчныг хамгаалах тухай хуульд нэмэлт өөрчлөлт оруулж байгаатай холбогдуулан Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуульд дараахь нэмэлт, өөрчлөлтийг оруулахаар боловсруулав.

Хуулийн 14 дүгээр зүйл буюу Төсөл, хөтөлбөр хэрэгжүүлэгчийн үүрэг гэсэн хэсэгт "иргэний хүсэлтийн дагуу өөрийн үйл ажиллагаатай холбоотой газрын хэвлийн баялгийг ашиглалтын нөхцөл байдал, байгаль орчинд үзүүлж байгаа нөлөөлөл, нөхөн сэргээлтийн явц, үр дүнгийн талаарх мэдээлэл өгөх, эсхүл танилцах боломжоор хангах үүрэгтэй." гэсэн заалт;

Мөн хуулийн 18 дугаар зүйл буюу Нөлөөллийн үнэлгээний үйл ажиллагааны олон нийтийн оролцоо гэсэн хэсэгт:

- “18.5.Иргэн тухайн нутаг дэвсгэрийн хүрээнд газрын хэвлийн баялгийн ашиглалтын нөхцөл байдал, байгаль орчинд үзүүлж байгаа нөлөөлөл, нөхөн сэргээлт болон төрийн эрх бүхий байгууллагаас хяналтын чиглэлээр хэрэгжүүлж байгаа арга хэмжээний талаар мэдээлэл авах хүсэлтийг аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг даргад гаргана.”

- “18.6.Засаг дарга иргэний энэ хуулийн 18.5-д заасан хүсэлтийн дагуу холбогдох мэдээллийг Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийн 14.8-д заасан хугацаанд гаргаж өгөх үүрэгтэй.”

- “18.7.Иргэн үйл ажиллагаатай нь холбогдуулан газрын хэвлийн баялгийн ашиглалтын нөхцөл байдал, байгаль орчинд үзүүлж байгаа нөлөөлөл, нөхөн сэргээлтийн талаарх мэдээлэл авах, танилцах боломж олгох хүсэлтийг төсөл хэрэгжүүлэгчид гаргаж болно.” гэсэн заалтыг тус тус нэмж Монгол Улсын Үндсэн Хуулийн нэмэлт, өөрчлөлттэй нийцүүлсэн болно.

Түүнчлэн хуулийн төсөлд олон нийтээс санал авах зорилгоор 2020 онд Байгаль орчин, аялал жуулчлалын яамны “www.mne.mn” цахим хуудаст 30 хоног байршуулсан бөгөөд ямар нэгэн санал ирээгүй болно.

Монгол Улсын Засгийн газар

Төсөл

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2021 оны ... дугаар
сарын ... -ны өдөр

Улаанбаатар
хот

БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ТУХАЙ ХУУЛЬД
НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Байгаль орчныг хамгаалах тухай хуульд доор дурдсан агуулгатай дараахь заалт нэмсүгэй:

1/4 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 7 дахь заалт:

“7/тухайн нутаг дэвсгэрийн хүрээнд газрын хэвлийн баялгийн ашиглалтын нөхцөл байдал, байгаль орчинд үзүүлж байгаа нөлөөлөл, нөхөн сэргээлт болон эрх бүхий байгууллагаас хяналтын чиглэлээр хэрэгжүүлж байгаа арга хэмжээний талаар мэдэх.”

2/16 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 11 дэх заалт:

“11/харьяа нутаг дэвсгэрийн хүрээнд газрын хэвлийн баялгийг ашиглалтын нөхцөл байдал, байгаль орчинд үзүүлж байгаа нөлөөлөл, нөхөн сэргээлт болон хяналтын чиглэлээр хэрэгжүүлсэн арга хэмжээний талаар иргэдэд нээлттэй мэдээлэх, байгаль орчны төлөв байдлын мэдээлэлд тусгаж, иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд тайлагнах.”

3/17 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 11 дэх заалт:

“11/харьяа нутаг дэвсгэрийн хүрээнд газрын хэвлийн баялгийг ашиглалтын нөхцөл байдал, байгаль орчинд үзүүлж байгаа нөлөөлөл, нөхөн сэргээлт болон хяналтын чиглэлээр хэрэгжүүлсэн арга хэмжээний талаар иргэдэд нээлттэй мэдээлэх, газрын хэвлийн баялгийн ашиглалтын талаар байгаль орчны төлөв байдлын мэдээлэлд тусгаж, иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд тайлагнах.”

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2021 оны ... дугаар
сарын ... -ны өдөр

Улаанбаатар
хот

БАЙГАЛЬ ОРЧИНД НӨЛӨӨЛӨХ БАЙДЛЫН ҮНЭЛГЭЭНИЙ
ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуульд доор дурдсан агуулгатай дараахь хэсэг, заалт нэмсүгэй:

1/18 дугаар зүйлийн 18.5, 18.6, 18.7 дахь хэсэг:

“18.5. Иргэн тухайн нутаг дэвсгэрийн хүрээнд газрын хэвлийн баялгийн ашиглалтын нөхцөл байдал, байгаль орчинд үзүүлж байгаа нөлөөлөл, нөхөн сэргээлт болон төрийн эрх бүхий байгууллагаас хяналтын чиглэлээр хэрэгжүүлж байгаа арга хэмжээний талаар мэдээлэл авах хүсэлтийг аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг даргад гаргана.

18.6. Засаг дарга иргэний энэ хуулийн 18.5-д заасан хүсэлтийн дагуу холбогдох мэдээллийг Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийн 14.8-д заасан хугацаанд гаргаж өгөх үүрэгтэй.

18.7. Иргэн үйл ажиллагаатай нь холбогдуулан газрын хэвлийн баялгийн ашиглалтын нөхцөл байдал, байгаль орчинд үзүүлж байгаа нөлөөлөл, нөхөн сэргээлтийн талаарх мэдээлэл авах, танилцах боломж олгох хүсэлтийг төсөл хэрэгжүүлэгчид гаргаж болно.”

2/14 дүгээр зүйлийн 14.1.4 дэх заалт:

“14.1.4. иргэний хүсэлтийн дагуу өөрийн үйл ажиллагаатай холбоотой газрын хэвлийн баялгийг ашиглалтын нөхцөл байдал, байгаль орчинд үзүүлж байгаа нөлөөлөл, нөхөн сэргээлтийн явц, үр дүнгийн талаарх мэдээлэл өгөх, эсхүл танилцах боломжоор хангах үүрэгтэй.”

2 дугаар зүйл. Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.5 дахь хэсгийн дугаарыг “18.8” гэж өөрчилсүгэй.

3 дугаар зүйл. Энэ хуулийг Байгаль орчныг хамгаалах тухай хуульд нэмэлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

**БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ
ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ХЭРЭГЦЭЭ, ШААРДЛАГЫГ
УРЬДЧИЛАН ТАНДАН СУДАЛСАН СУДАЛГААНЫ ТАЙЛАН**

УЛААНБААТАР ХОТ
2021 ОН

ГАРЧИГ

Нэг.Асуудалд дүн шинжилгээ хийх

- 1.1.Асуудлын хамрах хүрээг тогтоох
- 1.2.Эрх, ашиг сонирхол нь хөндөгдөж байгаа этгээдийг тодорхойлох
- 1.3.Асуудал үүсгэж буй учир шалтгааныг тогтоох

Хоёр.Зорилгыг томъёолох

Гурав.Асуудлыг зохицуулах хувилбаруудыг тогтоож, эерэг болон сөрөг талыг харьцуулан судлах

- 3.1.Асуудлыг зохицуулах хувилбаруудыг сонгох
- 3.2.Зохицуулалтын хувилбаруудын эерэг, сөрөг талыг үнэлэх
- 3.3.Харьцуулалтад үндэслэж хамгийн үр дүнтэй хувилбарыг тогтоох

Дөрөв.Зохицуулалтын хувилбарын үр нөлөөг тандан судлах

- 4.1.Хүний эрхэд үзүүлэх үр нөлөө
- 4.2.Эдийн засагт үзүүлэх нөлөө
- 4.3.Нийгэмд үзүүлэх нөлөө
- 4.4.Байгаль орчинд үзүүлэх нөлөө

Тав. Дүгнэлт, зөвлөмж

ХУУЛИЙН ХЭРЭГЦЭЭ ШААРДЛАГЫГ УРЬДЧИЛАН ТАНДАН СУДАЛСАН ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН

(Байгаль орчныг хамгаалах тухай хуульд нэмэлт
оруулах тухай хуулийн төсөл)

ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

Ардчилсан Үндсэн хууль буюу 1992 оны Үндсэн хуулийн зорилго, зарчим, агуулгад нийцүүлж 1995 онд Байгаль орчныг хамгаалах тухай хуулийг баталсан. Энэ хууль нь байгаль орчны салбарын суурь хууль юм.

Уг хуульд 1998 оноос хойш 24 удаа нэмэлт, өөрчлөлт орж улам баяжуулж, хийдэл, давхардал, зөрчлийг нь арилгасаар ирсэн.

Байгаль орчныг хамгаалах тухай хууль нь энэ салбарын ерөнхий суурь хууль бөгөөд 9 бүлэг, 59 зүйлээс бүрддэг.

Уг хуулиар газар, түүний хөрс, газрын хэвлий, түүний баялаг, ус, ургамал, амьтан, агаар гэсэн объектыг хэрхэн хамгаалах, зохистой ашиглах, байгаль орчны тэнцлийг хадгалах зэрэг суурь харилцааг зохицуулдаг.

Харин Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийг 1998 онд анх баталж, 2012 онд шинэчилсэн найруулга хийж дахин баталсан. Энэ хуулинд 2012 оноос хойш 2 удаа нэмэлт, өөрчлөлт оруулсан байна.

Энэхүү хууль нь 5 бүлэг, 20 зүйлээс бүрддэг бөгөөд байгаль орчныг хамгаалах, хүний үйл ажиллагааны улмаас байгаль орчны тэнцвэрт байдал алдагдахаас сэргийлэх, байгаль орчинд сөрөг нөлөөлөл багатайгаар байгалийн нөөц ашиглалт явуулах, бүс нутаг, салбарын хэмжээнд баримтлах бодлого, хэрэгжүүлэх хөгжлийн хөтөлбөр, төлөвлөгөө болон аливаа төслийн байгаль орчинд нөлөөлөх байдлыг үнэлэх, хэрэгжүүлэх эсэх талаар дүгнэлт, шийдвэр гаргах, оролцогч талуудын харилцааг зохицуулдаг.

Байгаль орчны асуудал нь дэлхийн хэмжээний асуудал болсон учраас дэлхийн улс орнуудын сайн жишгийг монголд нутагшуулахын тулд Байгаль орчин, аялал жуулчлалын яам өнгөрсөн жилүүдэд салбарын хууль тогтоомжоо тогтмол шинэчилсээр ирсэн.

Монгол Улсын Их Хурлаас Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийг 2019 оны 11 дүгээр сарын 14-ний өдөр баталсан.

Энэ өөрчлөлтөөр Үндсэн хуулийн зургадугаар зүйлийн хоёр дах хэсэгт "...Иргэн эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийнхээ хүрээнд газрын хэвлийн баялгийг ашигласнаар байгаль орчинд үзүүлэх нөлөөллийн талаар мэдэх эрхтэй..." гэсэн зохицуулалт орсон.

Үүний дагуу Засгийн газар 2020 оны 02 дугаар сарын 19-ний өдөр "Төлөвлөгөө батлах тухай" 66 дугаар тогтоолын хавсралтаар Үндсэн хуулийн зургадугаар зүйлд орсон дээрх зохицуулалтыг Байгаль орчныг хамгаалах тухай хууль, Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуульд оруулахаар баталсан.

Иймд яамны зүгээс дээрх хоёр хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийг төслийг боловсруулсан

УРЬДЧИЛАН ТАНДАН СУДЛАХ ҮНЭЛГЭЭНИЙ ТАЙЛАН

Байгаль орчныг хамгаалах тухай хууль, Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төсөл боловсруулах асуудал нь Хууль тогтоомжийн тухай хуулийн¹ 12 дугаар зүйлийн 12.2 дахь хэсэг болон Хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг урьдчилан тандан судлах аргачлалын² цаашид Аргачлал гэх/ 2.1-д заасан үе шатны дагуу хийж гүйцэтгэсэн болно.

НЭГ. АСУУДАЛД ДҮН ШИНЖИЛГЭЭ ХИЙСЭН БАЙДАЛ

Сүүлийн жилүүдэд байгаль орчны эрх зүйн орчинг сайжруулах, байгалийн нөөцийг зохистой ашиглах, менежментийг боловсронгуй болгох талаар бодлогын баримт бичигт тусгалаа олж, хэрэгжүүлэх талаар тодорхой үр дүнд хүрч байгаа боловч иргэд, олон нийтийн байгууллага газрын хэвлийн баялгийн ашиглалт, түүний нөлөөллийн талаар мэдэх эрх хангалтгүй байгаа болон иргэдийн оролцооны асуудал ихээр яригдах болсон.

Харин Монгол Улсын Их Хурлаас Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийг 2019 оны 11 дүгээр сарын 14-ний өдөр баталж энэ өөрчлөлтөөр Үндсэн хуулийн зургадугаар зүйлийн хоёр дахь хэсэгт "...Иргэн эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийнхээ хүрээнд газрын хэвлийн баялгийг ашигласнаар байгаль орчинд үзүүлэх нөлөөллийн талаар мэдэх эрхтэй..." гэсэн зохицуулалт орж үүний дагуу Засгийн газар 2020 оны 02 дугаар сарын 19-ний өдөр "Төлөвлөгөө батлах тухай" 66 дугаар тогтоолын хавсралтаар Үндсэн хуулийн зургадугаар зүйлд орсон дээрх зохицуулалтыг Байгаль орчныг хамгаалах тухай хууль, Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуульд оруулахаар баталсан

Иймд Аргачлалын 3-т заасны дагуу асуудалд дүн шинжилгээ хийхдээ асуудлыг тодорхойлж, шийдвэрлэх гэж байгаа тухайн асуудлын мөн чанар, цар хүрээг тогтоож, тухайн асуудлаар эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөж байгаа нийгмийн бүлэг, иргэн, аж ахуйн нэгж, байгууллага, бусад этгээдийг тодорхойлж, улмаар түүнийг үүсгэж байгаа шалтгаан, нөхцөлийг тодорхойлсон болно.

1.1. Асуудлын мөн чанар, цар хүрээг тодорхойлсон байдал:

Байгаль орчин, аялал жуулчлалын яам болон энэ чиглэлээр ажилладаг төрийн бус байгууллага, орон нутгийн захиргаанаас нөхцөл байдлын талаарх тайлан, лавлагаа, статистик тоон мэдээлэл цуглуулах, мөн асуудал хариуцсан мэргэжилтэн, төрийн бус байгууллагын төлөөлөлтэй ярилцлага хийх, энэ асуудлаар өмнө хийгдсэн судалгаа, мэдээлэл, тодорхой тохиолдлыг судлах хэлбэрээр тоон болон чанарын мэдээлэл цуглуулсан болно.

➤ Эрх зүйн зохицуулалт болон практик хэрэгжилтийн байдал:

Байгаль орчныг хамгаалах тухай, Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль тогтоомжид байгалийн нөөц баялагийг ашиглаж үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэх бүх төрлийн төслийн үйл ажиллагааны өмнө болон хэрэгжилтийн шатанд

¹ Төрийн мэдээлэл эмхтгэл. № 25. 2015 он.

² Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын нэгдүгээр хавсралт.

иргэдийн оролцоог хангах, иргэдэд байгаль орчны талаар мэдээлэл өгөх, мэдээллээр хангах асуудал хуульчлагдсан байна.

Тухайлбал: Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 4 дүгээр зүйлд иргэний эрх, үүргийг тодорхой заасан, хуулийн 15-17 дугаар зүйлд салбар яам, нутгийн өөрөө удирдах байгууллага, Засаг дарга нар иргэдийг мэдээллээр хангах асуудлыг тусгасан, мөн хуулийн 7 дугаар бүлэг буюу 33-44 дүгээр зүйл хүртэл Байгаль орчны мэдээллийн сангийн харилцааг зохицуулсан. Энэхүү мэдээллийн сан нь улсын хэмжээний байгаль орчны нэгдсэн мэдээллийн бааз болсон байна.

Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуульд байгаль орчны нөлөөллийн ерөнхий болон нарийвчилсан үнэлгээнд иргэдийн оролцоог тусгах, санал, хүсэлтийг нь авах, орон нутгийн байгууллагын санал, шүүмжлэлийг тусгах, байгаль орчинд учрах сөрөг нөлөөллийг бууруулах арга замыг тодорхой болгох, нөхөн сэргээлтийн хийх төлөвлөгөө, байгаль орчинд ээлтэй технологийн шийдэл зэргийг оруулдаг байна.

1.2. Эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөж байгаа этгээд:

Үндсэн хуулийн өөрчлөлтийг дагаж өөрчлөлт орж байгаа учраас хуулийн төслийн зохицуулалтууд нь иргэдийн эрх, хууль ёсны эрх ашиг сонирхлыг хөндөх асуудлыг бий болгохгүй бөгөөд тэдний эрх, ашиг сонирхолыг хамгаалахаар байна.

Эрх ашиг нь хөндөгдөх бүлэг		Нөлөөлж буй хэлбэр
1	Нийт иргэд	Иргэдийн Үндсэн хуульд заасан үндсэн эрхийг баталгаажуулж байна.
2	Орон нутгийн иргэд	Нутгийн иргэдийн мэдэх эрхийг баталгаажуулж, нутаг орныхоо төлөө санаа тавих, мэдээллээр хангагдах харилцааг бий болгож байна.
3.	Төр/төрийн албан хаагч	Төрийн байгууллага, албан хаагчид, иргэд хоорондын харилцааг сайжруулж, иргэддээ үйлчилдэг, шаардлагатай мэдээллийг тухай бүр гаргаж өгдөг болгож байна.

Дээрх нөлөөллүүд нь төр, иргэн, төрийн бус байгууллагын хамтын ажиллагааг дэмжсэн, төрд итгэх итгэлийг нэмэгдүүлсэн, байгалийн баялгийн ашиглалтын талаарх мэдээлэл нь ил тод, нээлттэй болох зэрэг эерэг нөлөөллийг харуулж байна.

Газрын хэвлийн баялгийг ашигласнаас үүдэх байгаль орчны нөлөөллийг мэдэх нь:

- Байгаль орчны асуудалд иргэд, аймаг, нийслэлийн Засаг дарга оролцох, санал, санаачилгийг төрийн дэмжлэгтэй хэрэгжүүлэх, үр шимийг нь ард иргэд хүртэх боломж нэмэгдэнэ;
- хяналтын тогтолцоо цогц болж, төрийн ачаалал, зардал буурна;
- олон нийтийн хяналтын тогтолцоо бүрдэнэ;
- нутгийн уугуул, ялангуяа уламжлалт аргаар мал аж ахуй эрхэлж буй иргэдийн зохион байгуулалт сайжирч, нутгийн бэлчээр, байгалийн баялгийг зөв зохистой ашигладаг болно;
- орон нутгийн иргэд нийгэм, эдийн засаг, байгаль орчны аливаа бэрхшээлтэй асуудлыг хохирол багатай, хамтран даван туулах боломж бүрдэнэ;

- ажлын байр нэмэгдэх, байгаль орчинд ээлтэй технологи нэвтрүүлэх зэргээр орон нутгийн иргэдийн амьжиргаа дээшилж, улмаар хэт төвлөрлийг сааруулах, орон нутгийг хөгжүүлэх;
- иргэдийн амьжиргааны өөр эх үүсвэр олоход дэмжлэг үзүүлнэ;

1.3. Асуудлыг үүсгэж буй учир шалтгаан:

Монгол Улсын Их Хурлаас Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийг 2019 оны 11 дүгээр сарын 14-ний өдөр баталж энэ өөрчлөлтөөр Үндсэн хуулийн зургадугаар зүйлийн хоёр дах хэсэгт "...Иргэн эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийнхээ хүрээнд газрын хэвлийн баялгийг ашигласнаар байгаль орчинд үзүүлэх нөлөөллийн талаар мэдэх эрхтэй..." гэсэн зохицуулалт орж үүний дагуу Засгийн газар 2020 оны 02 дугаар сарын 19-ний өдөр "Төлөвлөгөө батлах тухай" 66 дугаар тогтоолын хавсралтаар Үндсэн хуулийн зургадугаар зүйлд орсон дээрх зохицуулалтыг Байгаль орчныг хамгаалах тухай хууль, Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуульд оруулахаар баталсан.

Газрын хэвлийн баялгийг ашигласнаар байгаль орчинд үзүүлэх нөлөөллийн талаар иргэдийг мэдэх эрхээр хангах нь төрийн бүх шатны байгууллагын үүрэг болж байна. Байгаль орчны салбар нь мэдээллийн нэгдсэн сантай, үүнийгээ хуульчилж төрийн байгууллага, иргэд, олон нийтийг мэдээллээр хангах, санал хүсэлтээ гаргах боломжийг бий болгосон байна.

Энэхүү сайн туршлага, практикыг улам хөгжүүлэх, боловсронгуй болгох үүднээс Үндсэн хуульд орсон өөрчлөлтийг органик хуулийн процесс болгох, иргэдийн эрхийг улам баталгаажуулах шаардлага гарч байна.

ХОЁР. АСУУДЛЫГ ШИЙДВЭРЛЭХ ЗОРИЛГЫГ ТОДОРХОЙЛСОН БАЙДАЛ

Хуулийн төсөл батлагдсаар иргэд, төрийн байгууллагын харилцаа сайжирч, газрын хэвлийн баялгийн ашиглалтаас үүсэх байгаль орчны нөлөөллийн талаарх мэдээлэл нээлттэй болж иргэд, төрийн байгууллага, гадаад, дотоодтын хөрөнгө оруулагч байгууллагын хооронд үл ойлголцол үүсэх нөхцөл байдал арилна.

Иймд аргачлалын 4-т заасны дагуу асуудлыг шийдвэрлэх зорилгыг дараах байдлаар тодорхойлж байна:

Зорилго. "Газрын хэвлийн баялгийг ашигласнаас үүдэх байгаль орчны нөлөөллийн талаар иргэний мэдэх эрхийг баталгаажуулах, мэдээллийг ил тод нээлттэй болгох"

ГУРАВ. АСУУДЛЫГ ЗОХИЦУУЛАХ ХУВИЛБАРУУД, ТЭДГЭЭРИЙН ЭЭРЭГ, СӨРӨГ ТАЛЫГ ХАРЬЦУУЛСАН БАЙДАЛ

Асуудлыг шийдвэрлэх боломжтой хувилбаруудыг тогтоож, Аргачлалын 5-д заасны дагуу зорилгод хүрэх байдал буюу "Газрын хэвлийн баялгийг ашигласнаас үүдэх байгаль орчны нөлөөллийн талаар иргэний мэдэх эрхийг баталгаажуулах, мэдээллийг ил тод нээлттэй болгох" зорилгыг хангаж чадах эсэх, зардал, үр өгөөжийн харьцаа буюу

хувилбарыг хэрэгжүүлэхтэй холбоотой гарах зардал, үзүүлэх эерэг өөрчлөлтийг харьцуулан судалж дараах дүгнэлтийг гаргалаа:

Хувилбар	Зорилгод хүрэх байдал	Зардал, үр өгөөжийн харьцаа	Үр дүн
1 Тэг хувилбар	Өнөөгийн тулгамдаад байгаа бэрхшээл хэвээр үргэлжлэх бөгөөд зорилгод хүрэх боломжгүй.	Нэмэлт зардал гарахгүй бөгөөд тулгамдсан асуудал хэвээр үргэлжилнэ. Цаашид тулгамдсан асуудал нэмэгдэх болно.	Үр дүн сөрөг
2 Хэвлэл мэдээллийн хэрэгслээр ухуулга, сурталчилгаа хийх	Зорилгыг бүрэн хангахгүй ч иргэдийн идэвх, хяналт тодорхой хэмжээнд нэмэгдэх магадлалтай. Гэхдээ энэ нь асуудлыг сайжруулах нэг хэлбэр болохоос асуудлыг бүрэн шийдвэрлэх хувилбар биш.	Зардал тодорхой хэмжээнд гарна. Асуудлыг үүсгэж байгаа гол шалтгааныг арилгахад нөлөөлж, сөрөг үр дагаврыг бүрэн бууруулж чадахгүй.	Дангаараа үр дүнд хүрэхгүй
3 Зах зээлийн эдийн засгийн хэрэгслүүдийг ашиглан төрөөс зохицуулалт хийх	Тодорхой тохиолдолд татвар, хураамжаас чөлөөлөх, хөнгөлөлт, дэмжлэг үзүүлэх, урамшуулах нь үйл ажиллагааг дэмжих ач холбогдолтой ч тогтвортой байж чадахгүй.	Зардал шаардагдана. Гэвч асуудлыг үүсгэж байгаа гол шалтгааныг арилгахад нөлөөлж, сөрөг үр дагаврыг бууруулж чадахгүй.	Тодорхой үр дүнд хүрэхгүй
4 Төрөөс санхүүгийн интервенци хийх	Төрөөс шууд мөнгөн дэмжлэг үзүүлэх нь зарим талаар үйл ажиллагааг дэмжих хэдий ч түр зуурын арга хэмжээ тул зорилгыг хангаж чадахгүй.	Зардал их гарна. Асуудлыг үүсгэж байгаа гол шалтгааныг арилгахад нөлөөлж, сөрөг үр дагаврыг бууруулж чадахгүй.	Дангаараа үр дүнд хүрэхгүй
5 Захиргааны шийдвэр гаргах	Иргэн, аж ахуйн нэгж байгууллагыг татан оролцуулах хуулиар хүлээх хариуцлагыг нэмэгдүүлэх, ажиллах нийтлэг журмыг батлан мөрдүүлэх (Захиргааны ерөнхий хуульд нийцүүлэх) асуудлыг хуулийг хэрэгжүүлэх боломжгүй юм.	Асуудлыг үүсгэж байгаа шалтгааныг арилгахад цогцоор нөлөөлж, сөрөг үр дагаврыг бүрэн бууруулж чадахгүй.	Дангаараа үр дүнд хүрэхгүй

6	Хууль тогтоомжийн төсөл боловсруулах	Хуулиар хариуцлагыг нэмэгдүүлэх, иргэд, төрийн байгууллага, аж ахуйн нэгж, байгууллагын эрх, үүргийг тодорхой болгоно.	Хууль батлагдан гарсны дараа хууль хэрэгжүүлэх асуудлаар зардал гарах боловч гарч болох эерэг үр дүнтэй харьцуулахад бага байх бөгөөд энэ хувилбар нь асуудлыг үүсгэж байгаа гол шалтгааныг шийдвэрлэхэд чухал нөлөө үзүүлэх боломжтой.	Үр дүнтэй
---	--------------------------------------	--	---	-----------

Өнөөгийн тулгамдаад байгаа асуудлыг зохицуулалтгүй орхих, эсхүл хэвлэл мэдээллийн хэрэгслээр ухуулга сурталчилгаа хийх замаар иргэд, олон нийтийг мэдээллээр хангах, зах зээлийн эдийн засгийн хэрэгслүүдийг ашиглан төрөөс зохицуулалт хийх, эсхүл төрөөс шууд мөнгөн дэмжлэг үзүүлэх, захиргааны шийдвэр гаргаснаар тухайн асуудлыг үүсгэж байгаа гол шалтгааныг шийдвэрлэж, дэвшүүлсэн зорилгод хүрэх боломжгүй юм.

Иймд асуудлын мөн чанар, цар хүрээ болон нийгмийн хэрэгцээ шаардлагад нийцүүлэн хуулийн зохицуулах харилцааг өргөжүүлэх, чанар, үр өгөөжийг дээшлүүлэх зорилгод хүрэхийн тулд Байгаль орчныг хамгаалах тухай, Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг боловсруулах хувилбарыг сонгож байгаа тул Аргачлалын 5.5-д заасны дагуу тандан судлах ажиллагааг үргэлжлүүлж, тодорхойлсон зорилгын дагуу түүнд хүрэх дараах зохицуулалтын хувилбарыг дэвшүүлж байна:

- ✓ Хувилбар 1. “орон нутгийн засаг захиргааны байгууллага, иргэдийн оролцоог нэмэгдүүлэх”
- ✓ Хувилбар 2. Байгаль орчны мэдээллийг ил тод нээлттэй болгох, төрийн байгууллага, албан тушаалтнууд иргэдийн мэдэх эрхийг хангах

Нэгдүгээр хувилбарын хувьд хууль эрх зүйн зохицуулалтын хувилбарыг бий болгосноор нэг талаас даяаршин буй дэлхий нийтийн жишгийг хангах нөгөө талаас энэ талаар гарсан бодлогыг хэрэгжүүлэхэд дөхөм болохыг олон тооны судалгаа нотолдог.

Харин дээрх хоёр хуулиар иргэдийн мэдэх эрхтэй холбоотой зохицуулалтыг нарийвчлан тусгаснаар байгаль орчныг хамгаалах, зохистой ашиглах, нөхөн сэргээх ажилд ахиц дэвшил гарна.

Хоёрдугаар хувилбарын хувьд мөн адил байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх, зохистой ашиглахад иргэдийн оролцоог нэмэгдүүлэх, тэдний санал санаачлага, байр суурийг сонсох, шийдвэр гаргах түвшинд хүргэх, иргэдийн хяналтыг тогтоох ач холбогдолтой.

ДӨРӨВ. ЗОХИЦУУЛАЛТЫН ХУВИЛБАРЫН ҮР НӨЛӨӨГ ТАНДАН СУДАЛСАН БАЙДАЛ

Аргачлалын 6-д заасны дагуу сонгосон хувилбарын үр нөлөөг аргачлалд заасны дагуу ерөнхий асуултад хариулах замаар дүгнэлтийг нэгтгэн гаргалаа.

Жич: Хүний эрх, эдийн засаг, нийгэм, байгаль орчинд үзүүлэх үр нөлөөг шалгуур асуултын дагуу тандсан байдлыг хүснэгт 1, 2, 3, 4-өөс дэлгэрэнгүй үзнэ үү.

4.1. Хүний эрхэд үзүүлэх үр нөлөө

Иргэд тухайн нутаг дэвсгэртээ газрын хэвлийн баялгийг ашигласнаас үүдэх байгаль орчны нөлөөллийг мэдэх нь Үндсэн хуулиар олгогдсон үндсэн эрх бөгөөд үүнийг Байгаль орчныг хамгаалах, Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуульд нарийвчлан энэ чиглэлд иргэдийн хяналт сайжирч, улмаар иргэдэд хүргэх төрийн үйлчилгээний хүртээмж, чанар дээшлэнэ.

4.2. Эдийн засагт үзүүлэх үр нөлөө

Техник технологи, мэдээллийн хурдацтай хөгжлийн үр дүнд төрийн үйлчилгээг ил тод нээлттэй болгох, иргэн бүр дэлхий нийт, улс орны аливаа асуудлаар үзэл бодлоо илэрхийлэх, төрийн үйл ажиллагааг хянах өргөн боломжтой болсон.

Газрын хэвлийн баялгийг зохистой ил тод, нээлттэй ашиглах, байгаль орчинд үзүүлэх нөлөөллийг иргэд мэддэг байх зэрэг нь эдийн засгийн ил тод нээлттэй байдлыг хангах, мэдээллийн үнэн зөв урсгалд эдийн засгийг хөгжүүлэх ач холбогдолтой.

4.3. Нийгэмд үзүүлэх үр нөлөө

Байгаль орчныг хамгаалах, байгалийн нөөцийн үр ашигтай, хяналттай ашиглалтыг бий болгож, байгаль орчинд ээлтэй технологи нэвтрүүлсэнээр иргэдийн амьдрах орчинд эерэг нөлөө үзүүлнэ.

4.4. Байгаль орчинд үзүүлэх үр нөлөө

Энэхүү хуулийн төслүүдээр байгаль баялаг тэр дундаа газрын хэвлийн баялгийг ашигласнаас үүдэх нөлөөллийг иргэд нь мэддэг байх нарийвчилсан зохицуулалтыг бий болгосноор байгаль орчны аливаа асуудлыг шийдвэрлэх, иргэдийн оролцоог хөхүүлэн дэмжих, төрийн иргэний хамтын ажиллагааг хангана.

4.5. Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ, бусад хуультай нийцэж байгаа эсэх

Монгол Улсын Их Хурлаас Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийг 2019 оны 11 дүгээр сарын 14-ний өдөр баталсан.

Энэ өөрчлөлтөөр Үндсэн хуулийн зургадугаар зүйлийн хоёр дах хэсэгт "...Иргэн эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийнхээ хүрээнд газрын хэвлийн баялгийг ашигласнаар байгаль орчинд үзүүлэх нөлөөллийн талаар мэдэх эрхтэй..." гэсэн зохицуулалт орсон.

Үүний дагуу Засгийн газар 2020 оны 02 дугаар сарын 19-ний өдөр “Төлөвлөгөө батлах тухай” 66 дугаар тогтоолын хавсралтаар Үндсэн хуулийн зургадугаар зүйлд орсон дээрх зохицуулалтыг Байгаль орчныг хамгаалах тухай хууль, Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуульд оруулахаар баталсан.

Мөн Үндсэн хуульдаа “Монгол Улсад газар, түүний хэвлий, ой, ус, амьтан, ургамал болон байгалийн бусад баялаг гагцхүү ард түмний мэдэл, төрийн хамгаалалтад байна.”³, “Монгол Улсын иргэн нь эрүүл, аюулгүй орчинд амьдрах, орчны бохирдол, байгалийн тэнцэл алдагдахаас хамгаалуулах эрхтэй”⁴, “... байгаль орчноо хамгаалах нь иргэн бүрийн журамт үүрэг мөн”⁵ хэмээн хуульчилж, улмаар 1995 онд Байгалийн ургамлын тухай хуулийг батлан хэрэгжүүлж байна.

Монгол Улс нь 2016 оны байдлаар хүрээлэн буй орчныг хамгаалах чиглэлд олон талт олон улсын 22 гэрээнд нэгдсэн орсон байна.⁶

Байгаль орчны талаарх дараах конвенцэд Монгол Улс нэгдэн орж, хэрэгжүүлэх үүргийг хүлээсэн:

- ✓ Биологийн олон янз байдлын тухай Конвенц /1993.9.30/;
- ✓ Уур амьсгалын өөрчлөлтийн асуудлаарх НҮБ-ын суурь Конвенц /1994.3.21/;
- ✓ Озоны үе давхаргыг хамгаалах тухай /1985/ Венийн Конвенц;
- ✓ Озоны үе давхаргыг задалдаг бодисын тухайн Монреалын Протокол /1996.3.7/;
- ✓ Ган, цөлжилтөд ноцтой нэрвэгдэж буй орнуудын болон ялангуяа Африкийн цөлжилттэй тэмцэх тухай НҮБ-ын Конвенц /1996.9.3/;
- ✓ Олон улсын ач холбогдол бүхий ус, намгархаг газар ялангуяа усны шувууд олноор амьдардаг орчны тухай Конвенц /1997.6.5/;
- ✓ Био аюулгүй байдлын тухай Картагены протокол.

Монгол Улсын Үндсэн хуулийн Аравдугаар зүйлийн 10.3-т “Монгол Улсын олон улсын гэрээ нь соёрхон баталсан буюу нэгдэн орсон тухай хууль хүчин төгөлдөр болмогц дотоодын хууль тогтоомжийн нэгэн адил үйлчилнэ.” гэж заасан байдаг. Монгол Улсын Үндсэн хуулийн энэхүү заалтын дагуу байгалийн ургамлын талаар зохицуулж байгаа хууль тогтоомжууд нь агуулга, зарчмын хувьд эдгээр олон улсын гэрээ конвенцтэй нийцсэн байх шаардлагатай бөгөөд харин түүний заалтуудыг заавал хуулбарлан хуульчлах шаардлагагүй юм.

Иймд Хуулийн төслийн хувилбар нь Монгол Улсын Үндсэн хууль болон Монгол Улсын олон улсын гэрээнд нийцэх бөгөөд өнөөдөр үйлчилж байгаа бусад хууль тогтоомжийг аливаа хэлбэрээр зөрчөөгүй бөгөөд харин тэдгээрийн хууль зүйн хувьд хэлбэрэлтгүй хэрэгжүүлэхэд чухал нөлөө үзүүлэх юм.

ТАВ. ОЛОН УЛСЫН БОЛОН БУСАД УЛСЫН ХУУЛЬ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТТАЙ ХАРЬЦУУЛСАН БАЙДАЛ

³ Монгол Улсын Үндсэн хуулийн Зургадугаар зүйлийн 1.

⁴ Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургадугаар зүйлийн 2/.

⁵ Монгол Улсын Үндсэн хуулийн Арван долдугаар зүйлийн 2.

⁶ www.mfa.gov.mn цахим хуудас. Монгол Улсын нэгдсэн орсон олон талт гэрээ. Сүүлчийн нэвтрэлт 2017-4-18-ны өдөр.

Олон улсын эрх зүйн зохицуулалтыг судлан үзэхэд байгаль орчныг хамгаалахад байгалийн жам ёсны шүтэлцээг хангах нь сонгодог хэлбэр бөгөөд хүн төрөлхтний байгаль орчны тэнцвэрт байдлыг хангаж, тогтвортой хөгжлийн үзэл санааг хэрэгжүүлэх чухал арга гэдгийг НҮБ-ын “Тогтвортой хөгжлийн тунхаглал”, “Дэлхийн тунхаглал”, “Тогтвортой хөгжлийн XXI зууны үйл ажиллагааны хөтөлбөр” /НҮБ/, Байгаль орчин ба хөгжил” дэлхийн бага хурал. Рио-де Жанеро /1992/, Тогтвортой хөгжлийн талаарх Йоханнесбургийн тунхаглал, Йоханнесбург/2002/ зэрэг баримт бичигт хэмээн тодорхойлжээ.

1. Олон улсын жишиг

Арчилсан улсуудын иргэдийн эдэлдэг гол эрх нь байгаль орчны аливаа асуудлаа өөрсдөө мэддэг, байгалийн баялгийн ашиглалтад иргэд нь байнгын хяналт тавьдаг энэ талаар төрийн болон олон улсын байгууллагад асуудал дэвшүүлж шийдвэрлүүлдэг, төр нь иргэдээ мэдээллээр хангадаг суурь зарчимтай байна. АНУ, Канад болон Европын ихэнх орон энэ асуудлыг хуульчлан хүний үндсэн эрх болгосон бөгөөд энэ нь олон арван жил болж байна.

Мөн ОХУ нь 2002 онд Байгаль орчныг хамгаалах тухай хуулиа шинэчлэн баталсан бөгөөд уг хуульд зааснаар байгаль орчныг хамгаалах, зохистой ашиглах хүрээнд нутгийн иргэдийн оролцоог хангах, тэднийг урамшуулан дэмжих зохицуулалтыг тусгасан байна.

БНХАУ-ын Байгаль орчныг хамгаалах тухай хуулиа 1989 онд баталсан бөгөөд өнгөрсөн хугацаанд байгаль орчныг хамгаалах хуулиндаа 2014 онд анх удаа нэмэлт, өөрчлөлт оруулж байгаль орчны аливаа асуудлаар иргэдийн байр суурийг сонсох, тэдэнд мэдээлэл хүргэдэг байх арга хэмжээнүүд нэмж тусгасан байна.

ЗУРГАА. ЗӨВЛӨМЖ

Байгаль орчныг хамгаалах тухай, Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль тогтоомжид байгалийн нөөц байлгийг ашиглан үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэх бүх төрлийн төсөл хэрэгжүүлэгчийн үйл ажиллагаанд иргэдийн байгаль орчныг хамгаалах талаар оролцох оролцоо болон иргэдэд байгаль орчны талаар мэдээлэл өгөх, мэдээллээр хангах асуудал хуульчлагдсан байна.

Тухайлбал: Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 4 дүгээр зүйлд иргэний эрх, үүргийг тодорхой заасан, хуулийн 15-17 дугаар зүйлд салбар яам, нутгийн өөрөө удирдах байгууллага, Засаг дарга нар иргэдийг мэдээлэлээр хангах асуудлыг тусгасан, мөн хуулийн 7 дугаар бүлэг буюу 33-44 дүгээр зүйл хүртэл Байгаль орчны мэдээллийн сангийн харилцааг зохицуулсан. Энэхүү мэдээллийн сан нь улсын хэмжээнд ашиглах байгаль орчны нэгдсэн мэдээллийн бааз болсон бөгөөд иргэд, аж ахуйн нэгж, байгууллагууд уг мэдээллийн сангаас мэдээллийг нээлттэй авах боломжийг бүрдүүлсэн байна.

Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуульд байгаль орчны нөлөөллийн ерөнхий болон нарийвчилсан үнэлгээнд иргэдийн оролцоог хангах, санал, хүсэлтийг нь тусгах, орон нутгийн байгууллагын санал, шүүмжлэлийг тусгах, байгаль орчинд учрах сөрөг нөлөөллийг бууруулах арга замыг тодорхой болгох, нөхөн сэргээлт хийх төлөвлөгөө, байгаль орчинд ээлтэй технологийн шийдэл зэргийг зохицуулсан байна.

Мөн Монгол Улсын Их Хурал 1997 оны 106 дугаар тогтоолоор “Төрөөс экологийн талаар баримтлах бодлого”, 2010 онд 48 дугаар тогтоолоор “Монгол Улсын Үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлал”, 2016 онд 19 дүгээр тогтоолоор “Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030”, 2014 онд 43 дугаар тогтоолоор “Ногоон хөгжлийн бодлого” зэрэг баримт бичгүүдийг баталж байгаль орчны талаар хэрэгжүүлэх үе шаттай бодлого, арга хэмжээ, иргэдийн оролцоо зэргийг тусган хэрэгжүүлж ирсэн.

Иймд Үндсэн хуулийн өөрчлөлтийг хэрэгжүүлэх, иргэдийн үндсэн эрхийг салбар хуулиудаар баталгаажуулах, төр, иргэний хамтын ажиллагааг өргөжүүлэх үүднээс Байгаль орчныг хамгаалах тухай хууль, Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төсөл боловсруулах шаардлагатай гэж **Дүгнэж** байна.

Аргачлалын 9-д заасны дагуу энэхүү үнэлгээний тайлангийн холбогдох хэсгийг харьцуулан Байгаль орчныг хамгаалах тухай, Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах судалгаанд үндэслэсэн дараах зөвлөмжийг боловсрууллаа.

Хуулийн төслийг боловсруулахдаа хуулиар зайлшгүй зохицуулах шаардлагатай байгаа асуудлын цар хүрээнд тохируулан дараах зарчмын шинжтэй асуудлыг тусгах нь зүйтэй гэж **Зөвлөж** байна:

- ✓ *Байгаль орчныг хамгаалах тухай хуульд иргэний эрх, үүрэгт нэмэлт оруулах, аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг даргыг үүрэгжүүлэх заалт оруулах.*
- ✓ *Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуульд иргэдийн мэдэх эрхтэй холбоотой зохицуулалт оруулах, олон нийтийн оролцоо хангах нэмэлт заалт оруулах*

-----oOo-----

I. Ашигласан мэдээлэл, судалгаа, гарын авлага

1. Байгаль орчны төлөв байдлын тайлан. 2013-2014 он.
2. Байгаль орчны төлөв байдлын тайлан. 2015-2016 он.
3. Байгаль орчны төлөв байдлын тайлан. 2017-2018 он.
4. www.eic.mn
5. Монгол орны байгаль орчин 5 боть

II. Хууль тогтоомж

1. Монгол Улсын Үндсэн хууль;
2. Хууль тогтоомжийн тухай хууль;
3. Байгаль орчныг хамгаалах тухай хууль;
4. Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль

ХҮНИЙ ЭРХЭД ҮЗҮҮЛЭХ ҮР НӨЛӨӨ
(Хүснэгт 1)

Үзүүлэх үр нөлөө:	Холбогдох асуултууд	Хариулт		Тайлбар
1. Хүний эрхийн суурь зарчмуудад нийцэж буй эсэх	1.1. Ялгаварлан гадуурхахгүй ба тэгш байх			
	1.1.1.Ялгаварлан гадуурхахыг хориглох эсэх	Тийм	Үгүй	Хуулийн төслөөр холбогдох тавигдах шаардлага, шалгуурыг нийтлэг, тэгшээр хуульчлагдсан.
	1.1.2.Ялгаварлан гадуурхсан буюу аль нэг бүлэгт давуу байдал үүсгэх эсэх	Тийм	Үгүй	Иргэн, нийтийн ашиг сонирхлыг хамгаалж байгаа бөгөөд ялгаварлан гадуурхсан зохицуулалт байхгүй.
	1.1.3.Энэ нь тодорхой бүлгийн эмзэг байдлыг дээрдүүлэ-хийн тулд авч буй түр тусгай арга хэмжээ мөн бол олон улсын болон үндэсний хүний эрхийн хэм хэмжээнд нийцэж буй эсэх	Тийм	Үгүй	Байгаль орчинд ээлтэй байх зарчимд тулгуурлан сөрөг үр дагаварыг буруулахад зохицуулалтын зорилго чиглэгдэнэ.
	1.2. Оролцоог хангах			
	1.2.1.Зохицуулалтын хувилбарыг сонгохдоо оролцоог хангасан эсэх, ялангуяа эмзэг бүлэг, цөөнхийн оролцох боломжийг бүрдүүлсэн эсэх	Тийм	Үгүй	Холбогдох төрийн болон ТББ, аж ахуйн нэгж байгууллага, зэрэг эрх, ашиг сонирхол нь хөндөгдөж байгаа бүлгүүдтэй мэдээлэл хуваалцаж оролцоог хангасан.
	1.2.2.Ялангуяа зохицуулалтыг бий болгосноор эрх, хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөж буй, эсхүл хөндөгдөж болзошгүй иргэдийг тодорхойлсон эсэх	Тийм	Үгүй	Бүлгүүдийг тусгайлан тодорхойлж, тэдэнд үзүүлэх үр нөлөөг тооцсон.
	1.3. Хууль дээдлэх зарчим ба сайн засаглал хариуцлага			
	1.3.1.Зохицуулалтыг бий болгосноор хүний эрхийг хөхүүлэн дэмжих, хангах, хамгаалах явцад ахиц дэвшил гарах эсэх	Тийм	Үгүй	Үндсэн хуулийн өөрчлөлтийг дагаж хуульд нэмэлт, өөрчлөлт орж байгаа учраас иргэдийн эрхийг хөхүүлэн дэмжинэ.

	1.3.2. Зохицуулалтын хувилбар нь хүний эрхийн Монгол Улсын олон улсын гэрээ, НҮБ-ын хүний эрхийн механизмаас тухайн асуудлаар өгсөн зөвлөмжид нийцэж байгаа эсэх	Тийм	Үгүй	Шударга, тэгш, эерэг үр дүнтэй байх нөхцөл, боломжийг бүрдүүлэхэд чиглүүлсэн.
	1.3.3. Хүний эрхийг зөрчигчдэд хүлээлгэх хариуцлагыг тусгах эсэх	Тийм	Үгүй	Эрүүгийн болон Зөрчлийн тухай хуульд нийцэж байгаа учраас хариуцлага хүлээлгэх зохицуулалт тусгах шаардлагагүй.
2. Хүний эрхийг хязгаарласан зохицуулалт агуулсан эсэх	2.1. Зохицуулалт нь хүний эрхийг хязгаарлах бол энэ нь хууль ёсны зорилгод нийцсэн эсэх	Тийм	Үгүй	Хуулийн зорилго, шударга ёсонд нийцсэн шаардлагын үндсэн дээр иргэдийн байгалийн нөөц ашиглах эрхэнд тодорхой хязгаарлалт тогтооно.
	2.2. Хязгаарлалт тогтоох нь зайлшгүй эсэх	Тийм	Үгүй	Энэхүү хязгаарлалт нь нийтийн эрх ашиг, аюулгүй байдлын үүднээс зайлшгүй шаардлагатай бөгөөд Үндсэн хуульд заасан зайлшгүй нөхцөлд хамаарна.
3. Эрх агуулагч	3.1. Зохицуулалтын хувилбарт хамаарах бүлгүүд буюу эрх агуулагчдыг тодорхойлсон эсэх	Тийм	Үгүй	<ul style="list-style-type: none"> • Иргэн • Нутгийн оршин суугч • Хуулийн этгээд • ТББ
	3.2. Эрх агуулагчдыг эмзэг байдлаар нь ялгаж тодорхойлсон эсэх	Тийм	Үгүй	ҮХ-н өөрчлөлтийг дагаж гарч байгаа учраас ийм тодорхойлолт гаргах шаардлагагүй.
	3.3. Зохицуулалтын хувилбар нь энэхүү эмзэг бүлгийн нөхцөл байдлыг харгалзан үзэж, тэдний эмзэг байдлыг дээрдүүлэхэд чиглэсэн эсэх	Тийм	Үгүй	Хуулийн төслийн зохицуулалтууд иргэдийн орлогыг нэмэгдүүлэхэд, тэдгээрийн эрх зүйн байдлыг дээрдүүлэхэд чиглэсэн.
	3.4. Эрх агуулагчдын, ялангуяа эмзэг бүлгийн ялгаатай хэрэгцээг тооцсон мэдрэмжтэй зохицуулалтыг тусгах	Тийм	Үгүй	Хөгжлийн бэрхшээлтэй, үндэстний цөөнх, хэлний цөөнх зэрэг иргэдэд тэгшээр үйлчлэх, мөн орон нутагт үйл ажиллагаа явуулж байгаа

	эсэх /хөгжлийн бэрхшээлтэй, үндэстний цөөнх, хэлний цөөнх, гагцхүү эдгээрээр хязгаарлахгүй/			болон хуулийн этгээд, ТББ-уудад боломж олгоно.
Үүрэг хүлээгч	4.1. Үүрэг хүлээгчдийг тодорхойлсон эсэх	Тийм	Үгүй	Төр, хуулийн этгээд үүрэг хүлээнэ.
4. Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуульд нийцүүлсэн эсэх	5.1. Жендэрийн үзэл баримтлалыг тусгасан эсэх	Тийм	Үгүй	Бүх иргэдийн үндсэн эрхийг баталгаажуулсан.
	5.2. Эрэгтэй, эмэгтэй хүний тэгш эрх, тэгш боломж, тэгш хандлагын баталгааг бүрдүүлэх эсэх	Тийм	Үгүй	Хуулийн төслийн зохицуулалтууд бүхэлдээ жендэрийн тэгш байдлыг бүрдүүлсэн.

ЭДИЙН ЗАСАГТ ҮЗҮҮЛЭХ ҮР НӨЛӨӨ
(Хүснэгт 2)

Үзүүлэх үр нөлөө:	Холбогдох асуултууд	Хариулт		Тайлбар
1. Дэлхийн зах зээл дээр өрсөлдөх чадвар	1.1. Дотоодын аж ахуйн нэгж болон гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж хоорондын өрсөлдөөнд нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	1.2. Хил дамнасан хөрөнгө оруулалтын шилжилт хөдөлгөөнд нөлөө үзүүлэх эсэх (эдийн засгийн байршил өөрчлөгдөхийг оролцуулан)	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	1.3. Дэлхийн зах зээл дээрх таагүй нөлөөллийг монголын зах зээлд орж ирэхээс хамгаалахад нөлөөлж чадах эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
2. Дотоодын зах зээлийн өрсөлдөх чадвар болон тогтвортой байдал	2.1. Хэрэглэгчдийн шийдвэр гаргах боломжийг бууруулах эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	2.2. Хязгаарлагдмал өрсөлдөөний улмаас үнийн хөөрөгдлийг бий болгох эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй

	2.3.Зах зээлд шинээр орж ирж байгаа аж ахуйн нэгжид бэрхшээл, хүндрэл бий болгох эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	2.4.Зах зээлд шинээр монополийг бий болгох эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
3.Аж ахуйн нэгжийн үйлдвэрлэлийн болон захиргааны зардал	3.1.Зохицуулалтын хувилбарыг хэрэгжүүлснээр аж ахуйн нэгжид шинээр зардал үүсэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	3.2.Санхүүжилтийн эх үүсвэр олж авахад нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	3.3.Зах зээлээс тодорхой бараа бүтээгдэхүүнийг худалдан авахад хүргэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	3.4.Бараа бүтээгдэхүүний борлуулалтад ямар нэг хязгаарлалт, эсхүл хориг тавих эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	3.5.Аж ахуйн нэгжийг үйл ажиллагаагаа зогсооход хүргэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
4.Мэдээлэх үүргийн улмаас үүсч байгаа захиргааны зардлын ачаалал	4.1.Хуулийн этгээдэд захиргааны шинж чанартай нэмэлт зардал (Тухайлбал, мэдээлэх, тайлан гаргах г.м) бий болгох эсэх	Тийм	Үгүй	Нэмэлт зардал гарахгүй
5.Өмчлөх эрх	5.1.Өмчлөх эрхийг (үл хөдлөх, хөдлөх эд хөрөнгө, эдийн бус баялаг зэргийг) хөндсөн зохицуулалт бий болох эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	5.2.Өмчлөх эрх олж авах, шилжүүлэх болон хэрэгжүүлэхэд хязгаарлалт бий болгох эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	5.3.Оюуны (патент, өмчийн барааны	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй

	тэмдэг, зохиогчийн эрх зэрэг) эрхийг хөндсөн зохицуулалт бий болгох эсэх			
6.Инноваци болон судалгаа шинжилгээ	6.1.Судалгаа шинжилгээ, нээлт хийх, шинэ бүтээл гаргах асуудлыг дэмжих эсэх	Тийм	Үгүй	Энэ асуудлыг бүрэн дэмжинэ.
	6.2.Үйлдвэрлэлийн шинэ технологи болон шинэ бүтээгдэхүүн нэвтрүүлэх, дэлгэрүүлэхийг илүү хялбар болгох эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
7.Хэрэглэгч болон гэр бүлийн төсөв	7.1.Хэрэглээний үнийн түвшинд нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Эерэг нөлөө үзүүлнэ.
	7.2.Хэрэглэгчдийн хувьд дотоодын зах зээлийг ашиглах боломж олгох эсэх	Тийм	Үгүй	Эерэг нөлөө үзүүлнэ.
	7.3.Хэрэглэгчдийн эрх ашигт нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Эерэг нөлөө үзүүлнэ.
	7.4.Хувь хүний/гэр бүлийн санхүүгийн байдалд (шууд буюу урт хугацааны туршид) нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Иргэдийн амьжиргааны түвшинг сайжруулах, орлогыг нэмэгдүүлэх сайн талтай.
8.Тодорхой бүс нутаг, салбарууд	8.1.Тодорхой бүс нутагт буюу тодорхой нэг чиглэлд ажлын байрыг шинээр бий болгох эсэх	Тийм	Үгүй	Иргэн, хуулийн этгээдтэй гэрээний дагуу хамтран ажилласанаар түр болон байнгын ажлын байр бий болно.
	8.2.Тодорхой бүс нутагт буюу тодорхой нэг чиглэлд ажлын байр багасгах чиглэлээр нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	8.3.Жижиг, дунд үйлдвэр, эсхүл аль нэг салбарт нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Тухайн орон нутагт байгальд ээлтэй жижиг, дунд үйлдвэрлэл хөгжих боломжийг нэмэгдүүлнэ.
9.Төрийн захиргааны байгууллага	9.1.Улсын төсөвт нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Улсын төсөвт эерэг нөлөө үзүүлнэ.
	9.2.Шинээр төрийн байгууллага байгуулах, эсхүл төрийн байгууллагад бүтцийн	Тийм	Үгүй	Ямар нэгэн өөрчлөлт гарахгүй

	өөрчлөлт шаардлага эсэх	хийх тавигдах			
	9.3.Төрийн байгууллагад захиргааны шинэ чиг үүрэг бий болгох эсэх		Тийм	Үгүй	Ямар нэгэн шинэ чиг үүрэг үүсгэхгүй
10.Макро эдийн засгийн хүрээнд	10.1.Эдийн засгийн өсөлт болон ажил эрхлэлтийн байдалд нөлөө үзүүлэх эсэх		Тийм	Үгүй	Эерэг нөлөө үзүүлнэ.
	10.2.Хөрөнгө оруулалтын нөхцөлийг сайжруулах, зах зээлийн тогтвортой хөгжлийг дэмжих эсэх		Тийм	Үгүй	Эерэг нөлөө үзүүлнэ.
	10.3.Инфляци нэмэгдэх эсэх		Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
11.Олон улсын харилцаа	11.1.Монгол Улсын олон улсын гэрээтэй нийцэж байгаа эсэх		Тийм	Үгүй	Ямар нэгэн байдлаар зөрчилдөхгүй. Олон улсын гэрээ, хэлэлцээртэй нийцнэ.

НИЙГЭМД ҮЗҮҮЛЭХ ҮР НӨЛӨӨ
(Хүснэгт 3)

Үзүүлэх үр нөлөө:	Холбогдох асуултууд	Хариулт		Тайлбар
1 Ажил эрхлэлтийн байдал, хөдөлмөрийн зах зээл	1.1.Шинээр ажлын байр бий болох эсэх	Тийм	Үгүй	Шинээр ажлын байр бий болгохгүй
	1.2.Шууд болон шууд бусаар ажлын байрны цомхотгол бий болгох эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	1.3.Тодорхой ажил мэргэжлийн хүмүүс болон хувиараа хөдөлмөр эрхлэгчдэд нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Орон нутгийн иргэд, малчид, байгалийн үр шимийг шууд хүртэгчдэд эерэг нөлөө үзүүлнэ.
	1.4.Тодорхой насны хүмүүсийн ажил эрхлэлтийн байдалд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
2 Ажлын стандарт,	2.1.Ажлын чанар, стандартад нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй

хөдөлмөрлөх эрх	2.2.Ажилчдын эрүүл мэнд, хөдөлмөрийн аюулгүй байдалд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	2.3.Ажилчдын эрх, үүрэгт шууд болон шууд бусаар нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	2.4.Шинээр ажлын стандарт гаргах эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	2.5.Ажлын байранд технологийн шинэчлэлийг хэрэгжүүлэхтэй холбогдсон өөрчлөлт бий болгох эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
3.Нийгмийн тодорхой бүлгийг хамгаалах асуудал	3.1.Шууд болон шууд бусаар тэгш бус байдал үүсгэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	3.2.Тодорхой бүлэг болон хүмүүст сөрөг нөлөө үзүүлэх эсэх. Тухайлбал, эмзэг бүлэг, хөгжлийн бэршээлтэй иргэд, ажилгүй иргэд, үндэстний цөөнхөд гэх мэт	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	3.3.Гадаадын иргэдэд илэрхий нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
4.Төрийн удирдлага, сайн засаглал, шүүх эрх мэдэл, хэвлэл мэдээлэл, ёс суртахуун	4.1.Засаглалын харилцаанд оролцогчдод нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	4.2.Төрийн байгууллагуудын үүрэг, үйл ажиллагаанд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Төрийн байгууллагын ачаалал хөнгөрч, үндсэн чиг үүргээ хэрэгжүүлэхэд эерэг нөлөө үзүүлнэ. Мөн төрийн зүгээс тавих хяналт сайжирна.
	4.3.Төрийн захиргааны албан хаагчдын эрх, үүрэг, харилцаанд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Төрийн байгууллагын ачаалал хөнгөрч, үндсэн чиг үүргээ хэрэгжүүлэхэд эерэг нөлөө үзүүлнэ.
	4.4.Иргэдийн шүүхэд хандах, асуудлаа шийдвэрлүүлэх эрхэд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй

	4.5.Улс төрийн нам, төрийн бус байгууллагын үйл ажиллагаанд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Иргэдийн Үндсэн хууль болон энэ хуулиудаар олгогдсон эрхийг эдлүүлэх талд дээр оролцоо нь нэмэгдэнэ.
5.Нийтийн эрүүл мэнд, аюулгүй байдал	5.1.Хувь хүн/нийт хүн амын дундаж наслалт, өвчлөлт, нас баралтын байдалд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Хүн амын эрүүл аюулгүй орчинд амьдрахад эерэг нөлөө гарна.
	5.2.Зохицуулалтын хувилбарын улмаас үүсэх дуу чимээ, агаар, хөрсний чанарын өөрчлөлт хүн амын эрүүл мэндэд сөрөг нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	5.3.Хүмүүсийн амьдралын хэв маяг (хооллолт, хөдөлгөөн, архи, тамхины хэрэглээ)-т нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
6.Нийгмийн хамгаалал, эрүүл мэнд, боловсролын систем	6.1.Нийгмийн үйлчилгээний чанар, хүртээмжид нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Үйлчилгээний хүртээмж, чанар сайжирч эерэг нөлөө гарна.
	6.2.Ажилчдын боловсрол, шилжилт хөдөлгөөнд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй.
	6.3.Иргэдийн боловсрол (төрийн болон хувийн хэвшлийн боловсролын байгууллага) олох, мэргэжил эзэмших, давтан сургалтад хамрагдахад сөрөг нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	6.4.Нийгмийн болон эрүүл мэндийн үйлчилгээ авахад сөрөг нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	6.5.Их, дээд сургуулиудын үйл ажиллагаа, өөрийн удирдлагад нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	7.1.Нийгмийн аюулгүй байдал, гэмт хэргийн	Тийм	Үгүй	Байгаль орчны эсрэг гэмт хэргээс урьдчилан

7. Гэмт хэрэг, нийгмийн аюулгүй байдал	нөхцөл байдалд нөлөөлөх эсэх			сэргийлэх, илрүүлэх явц сайжирч, эерэг нөлөө гарна.
	7.2. Хуулийг албадан хэрэгжүүлэхэд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	7.3. Гэмт хэргийн илрүүлэлтэд нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	7.4. Гэмт хэргийн хохирогчид, гэрчийн эрхэд сөрөг нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
8. Соёл	8.1. Соёлын өвийг хамгаалахад нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	8.2. Хэл, соёлын ялгаатай байдал бий болгох эсэх, эсхүл уг ялгаатай байдалд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	8.3. Иргэдийн түүх, соёлоо хамгаалах оролцоонд нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Иргэдийн оролцоо, санаачлагыг нэмэгдүүлнэ.

БАЙГАЛЬ ОРЧИНД ҮЗҮҮЛЭХ ҮР НӨЛӨӨ
(Хүснэгт 4)

Үзүүлэх үр нөлөө:	Холбогдох асуултууд	Хариулт		Тайлбар
1. Агаар	1.1. Зохицуулалтын хувилбарын үр дүнд агаарын бохирдлыг нэмэгдүүлэх эсэх	Тийм	Үгүй	Агаарын бохирдлыг бууруулах эерэг нөлөөтэй.
2. Зам тээвэр, түлш, эрчим хүч	2.1. Тээврийн хэрэгслийн түлшний хэрэглээг нэмэгдүүлэх/бууруулах эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	2.2. Эрчим хүчний хэрэглээг нэмэгдүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	2.3. Эрчим хүчний үйлдвэрлэлд нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	2.4. Тээврийн хэрэгслийн агаарын	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй

	бохирдлыг нэмэгдүүлэх эсэх			
3. Ан амьтан, ургамлыг хамгаалах	3.1. Ан амьтны тоо хэмжээг бууруулах эсэх	Тийм	Үгүй	Амьтан, ургамал зэрэг байгалийн тэнцвэрт байдлыг хангахад эерэг нөлөө үзүүлнэ.
	3.2. Ховордсон болон нэн ховор амьтан, ургамалд сөргөөр нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Байгалийн ашигт ургамлыг тарьж ургуулах, хамгаалалтыг сайжруулах боломжтой байна.
	3.3. Ан амьтдын нүүдэл, суурьшилд сөргөөр нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй Хамгаалалтыг сайжруулах эерэг нөлөөтэй.
	3.4. Тусгай хамгаалалттай газар нутагт сөргөөр нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Тусгай хамгаалалттай газар нутагт сөрөг нөлөө байхгүй
4. Усны нөөц	4.1. Газрын дээрх ус болон гүний ус, цэвэр усны нөөцөд сөргөөр нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Усны нөөцийг хамгаалахад эерэг нөлөөллийг үзүүлнэ.
	4.2. Усны бохирдлыг нэмэгдүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй. Хамгаалалтыг сайжруулах эерэг нөлөөтэй.
	4.3. Ундны усны чанарт нөлөөлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
5. Хөрсний бохирдол	5.1. Хөрсний бохирдолтод нөлөө үзүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй. Хөрсийг нөхөн сэргээх, хамгаалахад чиглэсэн бөгөөд түүнийг бохирдуулах аливаа үйл ажиллагаа явуулахыг хориглосон зохицуулалттай.
	5.2. Хөрсийг эвдэх, ашиглагдсан талбайн хэмжээг нэмэгдүүлэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
6. Газрын ашиглалт	6.1. Ашиглагдаагүй байсан газрыг ашиглах эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	6.2. Газрын зориулалтыг өөрчлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй
	6.3. Экологийн зориулалтаар хамгаалагдсан газрын зориулалтыг өөрчлөх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй

7. Нөхөн сэргээгдэх/нөхөн сэргээгдэхгүй байгалийн баялаг	7.1. Нөхөн сэргээгдэх байгалийн баялгийг өөрөө нөхөн сэргээгдэх чадавхийг нь алдагдуулахгүйгээр зохистой ашиглах эсэх	Тийм	Үгүй	Ашиглалт, хамгаалалтад иргэд, төр аль аль нь зэрэгцээ хяналт тавих боломж нэмэгдэж, үр ашиг сайжирна.
	7.2. Нөхөн сэргээгдэхгүй байгалийн баялгийн ашиглалт нэмэгдэх эсэх	Тийм	Үгүй	Ямар нэгэн сөрөг нөлөө байхгүй

--- оОо ---

**БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ТУХАЙ ХУУЛЬД
НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСӨЛ**

Үр нөлөөллийн судалгаа

Улаанбаатар
2021 он

Судалгааг гүйцэтгэсэн:

БОАЖЯ-ны Хүрээлэн буй орчин, байгалийн нөөцийн удирдлагын газрын
Байгаль орчны үнэлгээ, аудитын хэлтэс

БОАЖЯ-ны Төрийн захиргааны удирдлагын газрын Хуулийн хэлтэс

Байгаль орчныг хамгаалах тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн үр нөлөө үнэлэх судалгааны тайлан

НЭГ. ЕРӨНХИЙ ЗҮЙЛ

Энэхүү үнэлгээг Байгаль орчин, аялал жуулчлалын яамнаас боловсруулсан хуулийн төслийн зүйл, заалтад Хууль тогтоомжийн тухай хуулийн¹ 17 дугаар зүйлд заасны дагуу дүн шинжилгээ хийх, үр нөлөөг тооцож, давхардал, хийдэл, зөрчлийг илрүүлэн, хуулийн зүйл, заалтыг ойлгомжтой, хэрэгжих боломжтой байдлаар боловсруулахад зөвлөмж өгөх зорилгоор гүйцэтгэлээ.

Үнэлгээ хийхээр сонгож авсан хуулийн төсөл нь хуулийн шинэчилсэн найруулгын төсөл² хэлбэрээр боловсруулагдсан байна.

Хуулийн төслийн нөлөөг үнэлэх ажиллагааг Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 3 дугаар хавсралтаар батлагдсан “Хуулийн төслийн үр нөлөө тооцох аргачлал”³-д /цаашид “Аргачлал” гэх/ заасны дагуу дараах үе шатаар хийлээ.

1. Шалгуур үзүүлэлтийг сонгох;
2. Хуулийн төслөөс үр нөлөө тооцох хэсгийг тогтоох;
3. Урьдчилан сонгосон шалгуур үзүүлэлтэд тохирох шалгах хэрэгслийн дагуу үр нөлөөг тооцох;
4. Үр дүнг үнэлэх, зөвлөмж өгөх.

ХОЁР. ХУУЛИЙН ТӨСЛИЙН ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛЭХ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТИЙГ СОНГОСОН БАЙДАЛ, ҮНДЭСЛЭЛ

Тус үнэлгээний ажлыг хийж гүйцэтгэхдээ хуулийн төслийн зорилго, хамрах хүрээ, зохицуулах асуудалтай уялдуулан Аргачлалын 2.9-д⁴ заасныг үндэслэн 6 шалгуур үзүүлэлтээс дараахь 4 шалгуур үзүүлэлтийг сонголоо.

Үүнд:

1. Зорилгод хүрэх байдал;
2. Практикт хэрэгжих боломж;
3. Ойлгомжтой байдал;
4. Харилцан уялдаа зэрэг болно.

¹ www.legalinfo.mn.

² “25.1.Дараах тохиолдолд хуулийн шинэчилсэн найруулгын төсөл боловсруулна:

25.1.4.тухайн хуулиар зохицуулж байгаа нийгмийн харилцааны төлөв байдал, агуулгад ихээхэн өөрчлөлт гарч, түүнтэй уялдуулан хуулийг шинэчлэн батлах шаардлагатай болсон..”

³ www.legalinfo.mn.

⁴ Хууль тогтоомжийн төслийн үр нөлөөг үнэлэх аргачлалын 2.9 “... хуулийн төслийн зорилго, хамрах хүрээ, зохицуулах асуудалтай уялдуулан нэг, эсхүл хэд хэдэн шалгуур үзүүлэлтийг сонгож болно”.

Шалгуур үзүүлэлтийг сонгосон үндэслэл:

➤ Зорилгод хүрэх байдал:

Энэхүү үнэлгээний үндсэн зорилго нь тухайн хуулийн төслийн зохицуулалт анх дэвшүүлсэн зорилго буюу тулгамдсан асуудлыг шийдвэрлэж чадах эсэхийг тогтоох юм. Иймд хуулийн төслийн зохицуулалт нь хуулийн төслийн үзэл баримтлал, хуулийн төслийг боловсруулах болсон үндэслэл, шаардлагад нийцсэн эсэх болон хуулийн төслөөр тулгамдсан асуудлыг шийдвэрлэж чадахуйц зохицуулалтын хувилбарыг агуулсан эсэхийг тогтоох зорилгоор тус шалгуур үзүүлэлтийг сонгосон болно.

➤ Практикт хэрэгжих боломж:

Газрын хэвлийн баялгийг ашигласнаас үүдэх байгаль орчны нөлөөллийг иргэн мэдэх эрхтэй байх нарийвчилсан зохицуулалтыг тусгана. Эдгээр зохицуулалт нь хэрэгжих боломжтой эсэхийг тодруулах шаардлагатайг харгалзан тус шалгуур үзүүлэлтийг сонгосон.

➤ Ойлгомжтой байдал:

Хуулийн зохицуулалт нь түүнийг хэрэглэх, хэрэгжүүлэх субъектийн хувьд ойлгомжтой байх нь хэрэгжилтийн үр дүнд шууд нөлөөлдөг.

Хууль тогтоомжийн тухай хуульд зааснаар хуулийн төсөл нь бүтэц, хэлбэрийн хувьд логик дараалалтай, хэл зүй, найруулгын хувьд тодорхой, ойлгоход хялбараар томъёологдсон байх шаардлага тавигддаг.

Энэхүү хуулийн төсөл нь Хууль тогтоомжийн тухай хууль, Хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлалд⁵ заасан шаардлагыг хангасан эсэхийг хянан тогтоох зорилгоор энэхүү шалгуур үзүүлэлтийг сонгосон болно.

➤ Харилцан уялдаа:

Хуулийн төслийн эх бичвэр нь хүчин төгөлдөр үйлчилж байгаа бусад хууль тогтоомжтой, мөн төсөлд тусгагдсан зохицуулалт нь өөр хоорондоо зөрчилгүй байх, хуулиар үүрэг хүлээсэн субъектүүдийн чиг үүрэг давхардал, зөрчилгүй байх шаардлагатай.

Иймд хуулийн төсөл нь Хууль тогтоомжийн тухай хуульд заасан агуулгын шаардлагыг⁶ хангасан эсэхийг шалгах зорилгоор тус шалгуур үзүүлэлтийг сонгосон.

“Хүлээн зөвшөөрөгдөх байдал болон зардал тооцох” шалгуур үзүүлэлтийг сонгоогүй тухай:

⁵ Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 2 дугаар хавсралт.

⁶ Хууль тогтоомжийн тухай хуулийн 29 дүгээр зүйл.

Ардчилсан Үндсэн хууль буюу 1992 оны Үндсэн хуулийн зорилго, зарчим, агуулгад нийцүүлж 1995 онд Байгаль орчныг хамгаалах тухай хуулийг баталсан. Энэ хууль нь байгаль орчны салбарын суурь хууль юм.

Мөн 1998 оноос хойш 24 удаа нэмэлт, өөрчлөлт орж улам баяжуулж, хийдэл, давхардал, зөрчлийг нь арилгасаар ирсэн.

Харин Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийг 1998 онд анх баталж, 2012 онд шинэчилсэн найруулга хийж дахин баталсан. Энэ хуулинд 2012 оноос хойш 2 удаа нэмэлт, өөрчлөлт оруулсан.

Үндсэн хуулийн өөрчлөлтийг дагаж дээрх хоёр хуульд нэмэлт орж байгаа бөгөөд хуулийн төслийн үзэл баримтлал, төслийн зорилт, зохицуулалтаас үзэхэд байгаль орчныг хамгаалах, байгалийн баялгийг зохистой ашиглах, нөхөн сэргээх зарчим хэвээр хадгалагдахаар байна.

Иймд хуулийн төсөлд тусгагдсан зохицуулалтын хүрээнд хамрагдах этгээд (иргэн, хуулийн этгээд) хүлээн зөвшөөрөх эсэхийг тодруулах зорилт бүхий **“хүлээн зөвшөөрөгдөх байдал”** шалгуур үзүүлэлтээр үнэлгээ хийх шаардлагагүй гэж үзсэн болно.

Мөн дээрх үндэслэлээс гадна тухайн хуулийн төслийг хэрэгжүүлэхтэй холбоотой гарах зардлын тооцоог тусгайлан хийсэн тул **“зардал тооцох”** шалгуур үзүүлэлтийг сонгоогүй болно.

ГУРАВ. ХУУЛИЙН ТӨСЛӨӨС ҮР НӨЛӨӨГ ҮНЭЛЭХ ХЭСГИЙГ ТОГТООСОН БАЙДАЛ

Сонгосон шалгуур үзүүлэлтийн дагуу үр нөлөөг үнэлэхэд хамруулах хэсэг, түүнийг шалгах хэрэгслийг дараах байдлаар тогтоолоо.

Хүснэгт-1

д/д	Шалгуур үзүүлэлт	Үр нөлөөг үнэлэх хэсэг	Шалгах хэрэгсэл
1	Зорилгод хүрэх байдал	Хуулийн төслийн холбогдох зохицуулалт	Хуулийн төслийн үзэл баримтлалд дэвшүүлсэн зорилтыг хангах эсэхэд дүн шинжилгээ хийх.
2	Практикт хэрэгжих боломж	Хуулийн төслийн 5, 6, 7, 8, 10, 11, 12, 15, 16, 17, 19 дугаар зүйл	Хуулийн зохицуулалтад хамрагдах байгууллагын төлөөлөлтэй ярилцлага зохион байгуулах, статистик мэдээ, хуулийн төсөлд ирүүлсэн саналуудад дүн шинжилгээ хийх.

3	Ойлгомжтой байдал	Хуулийн төслийг зохицуулалтыг бүхэлд нь хамруулах	Хууль тогтоомжийн тухай хуулийн 23, 28, 29, 30 дугаар зүйл, Хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлалд заасан шаардлагыг хангасан эсэхийг шалгах.
4	Харилцан уялдаа	Хуулийн төслийг зохицуулалтыг бүхэлд нь хамруулах	Хууль тогтоомжийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.1, 29.1.5, 29.1.7, 29.1.10-т болон Аргачлалын 4.10-т заасан шаардлага, шалгуурыг хангасан шалгах.

1. Зорилгод хүрэх байдлыг хангасан эсэх:

“Зорилгод хүрэх байдал” гэсэн шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуульд нэмэлт оруулах хуулийн төслийн үзэл баримтлалд тусгасан хуулийн төсөл боловсруулах болсон үндэслэл, хэрэгцээ шаардлагад тухайн хуулийн төслийн зорилго, зохицуулалтууд нь нийцэж байгаа эсэхэд дүн шинжилгээ хийхийг зорьсон.

Энэ дагуу хуулийн төслийн үзэл баримтлалтай танилцаж, үзэл баримтлал болон хуулийн төслийн зорилго, түүнийг хангахад чиглэсэн зохицуулалтуудыг харьцуулах байдлаар дүн шинжилгээ хийлээ.

Хуулийн төслийн үзэл баримтлал, хуулийн төслийн бүтэц, зохицуулах зүйлийн хүрээ, агуулгад дүн шинжилгээ хийж үзвэл хоёр хуулийн зохицуулалтыг өргөжүүлж, дараах зорилтуудад тулгуурлан шинэчлэхээр зорьсон байна:

1. Хүний эрхийн түгээмэл тунхаглал зэрэг олон улсын гэрээ конвенцод заасан холбогдох иргэний үндсэн эрхийг бодитоор хуульчлах, аймаг, нийслэл, сум дүүргийн Засаг дарга нар хууль тогтоомжийг хэрэгжүүлэх үүрэг, төсөл хэрэгжүүлэгч нь иргэний мэдэх эрхийг хангах зэргийг хуульчилна.

2. Монгол Улсын Үндсэн хуульд орсон өөрчлөлтийг салбар хуулиадад тусгаж иргэний мэдэх эрхийг бодитоор эдлүүлэх харилцааг хуульчилна.

Дээр дурдсан зорилтуудыг хангах чиглэлээр тодорхой зохицуулалтыг хуулийн төсөлд тусгасан байдлыг шалгаж үзвэл:

Иргэд нутаг орныхоо байгалийн баялагт хяналт тавьдаг, аливаа нөлөөллийг мэдэх эрхтэй байх нь тэдний эрүүл аюулгүй, ирээдүйдээ итгэлтэй тайван амьдрах баталгаа бөгөөд хуулийн төслүүдээр энэ харилцааг зохицуулж байгаа нь хүний эрхийн олон улсын суурь зарчимд нийцэж байна.

2. Практикт хэрэгжих боломжтой эсэх:

Байгаль орчныг хамгаалах тухай хуульд нэмэлт оруулах тухай, Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуульд нэмэлт, өөрлөлт оруулах тухай хуулийн төслийн 1 дүгээр зүйлд заасан зохицуулалтуудыг “Практикт хэрэгжих боломж” шалгуур үзүүлэлтээр шалган бодит байдалд хэрэгжих боломжтой эсэх, хэрэгжүүлэгч субъектүүдэд ачаалал, бэрхшээл учруулах эсэх, учирч болох эрсдлийг буруулах арга зам байгаа эсэхийг тодруулахыг зорилгоор холбогдох байгууллагуудын статистик мэдээ, хуулийн төсөлд ирүүлсэн саналуудад дүн шинжилгээ хийх замаар шалгасан болно.

➤ Байгаль орчныг хамгаалах тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төслийн зохицуулалт:

Хуулийн төслийн 1 дүгээр зүйлээр дараах зохицуулалтыг нэмэхээр тусгасан байна:

1 дүгээр зүйл. Байгаль орчныг хамгаалах тухай хуульд доор дурдсан агуулгатай дараах заалт нэмсүгэй:

1/4 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 7 дахь заалт:

“7/тухайн нутаг дэвсгэрийн хүрээнд газрын хэвлийн баялгийн ашиглалтын нөхцөл байдал, байгаль орчинд үзүүлж байгаа нөлөөлөл, нөхөн сэргээлт болон эрх бүхий байгууллагаас хяналтын чиглэлээр хэрэгжүүлж байгаа арга хэмжээний талаар мэдэх.”

2/16 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 11 дэх заалт:

“11/харьяа нутаг дэвсгэрийн хүрээнд газрын хэвлийн баялгийг ашиглалтын нөхцөл байдал, байгаль орчинд үзүүлж байгаа нөлөөлөл, нөхөн сэргээлт болон хяналтын чиглэлээр хэрэгжүүлсэн арга хэмжээний талаар иргэдэд нээлттэй мэдээлэх, байгаль орчны төлөв байдлын мэдээлэлд тусгаж, иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд тайлагнах.”

3/17 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 11 дэх заалт:

“11/харьяа нутаг дэвсгэрийн хүрээнд газрын хэвлийн баялгийг ашиглалтын нөхцөл байдал, байгаль орчинд үзүүлж байгаа нөлөөлөл, нөхөн сэргээлт болон хяналтын чиглэлээр хэрэгжүүлсэн арга хэмжээний талаар иргэдэд нээлттэй мэдээлэх, газрын хэвлийн баялгийн ашиглалтын талаар байгаль орчны төлөв байдлын мэдээлэлд тусгаж, иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд тайлагнах.”

Эдгээр зохицуулалтууд нь практикт хэрэгжих боломжтой гэж үзэж байна. Учир нь одоо мөрдөгдөж байгаа хуулиар байгаль орчны мэдээллийн сантай холбоотой бүлэг хуульчлагдсан бөгөөд салбар яам, бүх шатны Засаг дарга, түүний харьяа байгууллага байгаль орчны мэдээллийг гаргаж мэдээллийн санд оруулах, шаардлагатай мэдээллийг эрх бүхий байгууллагад нэгтгэн гаргаж уг мэдээллийн санд бүртгэж байна. Энэхүү нэмэлт нь газрын хэвлийн баялгийг ашигласантай холбоотой нөлөөлөл гэж тусгайлан зааснаараа л онцлог юм.

Байгаль орчныг хамгаалах тухай хуульд нэмэлт оруулж буйтай холбогдуулан дагаж Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуульд нэмэлт, өөрлөлт оруулах тухай хуулийн төслийн зүйлийн зохицуулалт:

1 дүгээр зүйл. Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуульд доор дурдсан агуулгатай дараах хэсэг, заалт нэмсүгэй:

1/18 дугаар зүйлийн 18.5, 18.6, 18.7 дахь хэсэг:

“18.5.Иргэн тухайн нутаг дэвсгэрийн хүрээнд газрын хэвлийн баялгийн ашиглалтын нөхцөл байдал, байгаль орчинд үзүүлж байгаа нөлөөлөл, нөхөн сэргээлт болон төрийн эрх бүхий байгууллагаас хяналтын чиглэлээр хэрэгжүүлж байгаа арга хэмжээний талаар мэдээлэл авах хүсэлтийг аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг даргад гаргана.

18.6.Засаг дарга иргэний энэ хуулийн 18.5-д заасан хүсэлтийн дагуу холбогдох мэдээллийг Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийн 14.8-д заасан хугацаанд гаргаж өгөх үүрэгтэй.

18.7.Иргэн үйл ажиллагаатай нь холбогдуулан газрын хэвлийн баялгийн ашиглалтын нөхцөл байдал, байгаль орчинд үзүүлж байгаа нөлөөлөл, нөхөн сэргээлтийн талаарх мэдээлэл авах, танилцах боломж олгох хүсэлтийг төсөл хэрэгжүүлэгчид гаргаж болно.”

2/14 дүгээр зүйлийн 14.1.4 дэх заалт:

“14.1.4.иргэний хүсэлтийн дагуу өөрийн үйл ажиллагаатай холбоотой газрын хэвлийн баялгийг ашиглалтын нөхцөл байдал, байгаль орчинд үзүүлж байгаа нөлөөлөл, нөхөн сэргээлтийн явц, үр дүнгийн талаарх мэдээлэл өгөх, эсхүл танилцах боломжоор хангах үүрэгтэй.”

2 дугаар зүйл. Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.5 дахь хэсгийн дугаарыг “18.8” гэж өөрчилсүгэй.

3 дугаар зүйл. Энэ хуулийг Байгаль орчныг хамгаалах тухай хуульд нэмэлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

...Гэж заасан нь практикт хэрэгжих бүрэн боломжтой бөгөөд газрын хэвлийн баялгийг ашигласнаар байгаль орчинд үзүүлэх нөлөөллийн талаар иргэний мэдэх эрхийг баталгаажуулж байгаа болно.

Мөн хуулийн төсөл нь Хууль тогтоомжийн тухай хуулийн 29 дүгээр зүйлд заасан тухайн хуулиар зохицуулах нийгмийн харилцаанд хамаарах асуудлыг бүрэн тусгасан байх, үүнд хүрээнээс хальсан асуудлыг тусгахгүй байх, 30 дугаар зүйлд заасан хэл зүй, найруулгын ерөнхий шаардлагад нийцсэн байна.

4.Харилцан уялдаатай байдлыг хангасан эсэх:

“Харилцан уялдаа” гэсэн шалгуур үзүүлэлтийн хүрээнд хуулийн төслийг аргачлалд тусгасан хуулийн төслийн үр нөлөөг үнэлэх стандарт асуултуудад хариулах замаар уялдаа холбоог шалгахын тулд хуулийн төслийг бүхэлд нь авч үзэхээр тооцлоо.

Хууль тогтоомжийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.1, 29.1.5, 29.1.7, 29.1.10 –т болон Аргачлалын 4.10-т заасан шаардлага, шалгуурын дагуу үнэллээ:

- Хууль тогтоомжийн тухай хуулийн 29 дүгээр зүйлд заасан шаардлагыг хангасан эсэх:

Д/д	Шалгах асуулт	Шаардлагыг хангасан эсэх
1	29.1.1.Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээнд нийцсэн, бусад хууль, үндэсний аюулгүй байдлын үзэл баримтлалтай уялдсан байх	Үндсэн хуульд заасан зарчмыг хангахад чиглэсэн бөгөөд ямар нэгэн байдлаар зөрчилдөөгүй байна.
2	29.1.5.зүйл, хэсэг, заалт нь хоорондоо зөрчилгүй байх	Төслийн зүйл, заалт хоорондоо зарчмын томоохон зөрчил байхгүй байна.
3	29.1.7.бусад хуулийн заалтыг давхардуулан заахгүйгээр шаардлагатай бол түүнийг эш татах, энэ тохиолдолд эшлэлийг тодорхой хийж, хуулийн нэр болон хэвлэн нийтэлсэн албан ёсны эх сурвалжийг бүрэн гүйцэд заасан байх	Энэхүү хуулийн төсөлд зүйл, заалт хооронд эшлэл хэрэглэсэн байна. Иймд хуулийн төслийн зохицуулалтын өөрчлөлт, засварыг харгалзан, эшлэлийг нягтлах нь зүйтэй байна.
4	29.1.10.шаардлагатай тохиолдолд бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах болон хууль хүчингүй болсонд тооцох тухай дагалдах хуулийн төслийг боловсруулсан байх	Тус хуулийн төслийг дагаж нэмэлт, өөрчлөлт оруулах Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн төслийг боловсруулсан байна.

- Аргачлалын 4.10-т заасан шалгуурыг хангасан эсэх:

○

д/д	Асуулт	Хариулт	Дүн шинжилгээ
1	Хуулийн төслийн зохицуулалт тухайн хуулийн зорилттой нийцэж байгаа эсэх	Тийм	Хуулийн төслийн зохицуулалт нь үзэл баримтлалд тусгагдсан зорилтыг бүрэн хангаж байна.
2	Хуулийн төслийн “Хууль тогтоомж” гэсэн хэсэгт заасан хуулиудын нэр тухайн	Тийм	Энэхүү шаардлагыг хангасан байна.

	харилцаанд хамаарах хууль мөн эсэх		
3	Хуулийн төсөлд тодорхойлсон нэр томъёо тухайн хуулийн төслийн болон бусад хуулийн нэр томъёотой нийцэж байгаа эсэх	Тийм	Нийцэж байна.
4	Хуулийн төслийн зүйл, заалт тухайн хуулийн төсөл болон бусад хуулийн заалттай нийцэж байгаа эсэх	Тийм	Дүн шинжилгээний хүрээнд зарчмын зөрүүтэй ямар нэгэн асуудал илрээгүй бөгөөд тодруулах, нэмэлт хийх шаардлагатай зохицуулалт байна.
5	Хуулийн төслийн зүйл, заалт тухайн хуулийн төслийн болон бусад хуулийн заалттай давхардсан эсэх	Үгүй	Энэхүү шаардлагыг хангасан байна.
6	Хуулийн төслийг хэрэгжүүлэх этгээдийг тодорхой тусгасан эсэх	Тийм	Хуулийн төслийг хэрэгжүүлэгч субъектүүдийн эрх үүргийг ялган тодорхойлсон байна.
7	Хуулийн төсөлд шаардлагатай зохицуулалтыг орхигдуулсан эсэх	Үгүй	Хуулийн төсөлд оруулах шаардлагатай орхигдуулсан зохицуулалт байхгүй байна.
8	Хуулийн төсөлд төрийн байгууллагын гүйцэтгэх чиг үүргийг давхардуулан тусгасан эсэх	Үгүй	Хяналтаар ямар нэгэн зөрчилтэй зохицуулалт илрээгүй.
9	Төрийн байгууллагын чиг үүргийг төрийн бус байгууллага, мэргэжлийн холбоодоор гүйцэтгүүлэх боломжтой эсэх	-	Энэхүү зохицуулалтыг нарийвчлан тодорхой зарчмыг тогтоосон байна.
10	Татварын хуулиас бусад хуулийн төсөлд албан татвар, төлбөр, хураамж тогтоосон эсэх	Үгүй	Хяналтаар ямар нэгэн зөрчилтэй зохицуулалт илрээгүй.
12	Монгол Улсын Үндсэн хууль болон Монгол Улсын олон улсын гэрээнд заасан хүний эрхийг хязгаарласан зохицуулалт тусгасан эсэх	Үгүй	Хуулийн төсөлд тусгасан хязгаарлалт нь Монгол Улсын Үндсэн хуульд нийцсэн, хуульд заасан зайлшгүй бөгөөд хүний хууль ёсны ашиг сонирхлыг хуулиас гадуур хөндөхгүй байх нөхцөлийг тусгасан байна.
13	Хуулийн төслийн зүйл, заалт жөндөрийн эрх тэгш байдлыг хангасан эсэх	-	Хуулийн төсөлд тусгайлан зохицуулалт тусгагдаагүй бөгөөд энэ асуудлыг Жөндөрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн хүрээнд зохицуулах боломжтой.

14	Хуулийн төсөлд шударга бус өрсөлдөөнийг бий болгоход чиглэсэн заалт тусгагдсан эсэх	-	Ийм заалт тусгагдаагүй байна.
15	Хуулийн төсөлд авлига, хүнд суртлыг бий болгоход чиглэсэн заалт тусгагдсан эсэх	Үгүй	Хяналтаар энэ төрлийн зөрчил илрээгүй. Тус төслийн зохицуулалт нь өмнөх эрх зүйн зохицуулалтын хүрээнд байсан тодорхойгүй, мэдээлэл, санхүүжилтийн нууцлагдмал байдлыг өөрчлөн, сайжруулсан давуу талтай хэмээн дүгнэж байна.
16	Хуулийн төсөлд тусгасан хориглосон хэм хэмжээг зөрчсөн этгээдэд хүлээлгэх хариуцлагын талаар тодорхой тусгасан эсэх.	-	Тухайн хуулийг зөрчсөн этгээдэд хүлээлгэх хариуцлагыг Эрүүгийн хууль, Зөрчлийн тухай хууль, Төрийн албаны тухай хууль болон энэ хуулиар зохицуулахаар тусгасан байна.

Энэхүү шалгуур үзүүлэлтийн дагуу дүн шинжилгээ хийж үзэхэд хуулийн төслийн зүйл заалт өөр хоорондоо болон Монгол Улсын Үндсэн хууль, бусад хүчин төгөлдөр үйлчилж байгаа хууль тогтоомжтой зарчмын хувьд зөрчилдөөгүй, үүрэг хүлээсэн байгууллага, албан тушаалтнуудын чиг үүрэгт давхардал үүсгээгүй байна.

ДӨРӨВ. ҮР ДҮНГ ҮНЭЛЖ, ЗӨВЛӨМЖ ӨГСӨН БАЙДАЛ

Энэхүү үр нөлөө тооцох үнэлгээг Байгаль орчин, аялал жуулчлалын яамнаас боловсруулсан Байгаль орчныг хамгаалах тухай хуульд нэмэлт оруулах, түүнийг дагалдан нэмэлт, өөрчлөлт оруулах Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн төслийн үзэл баримтлал, танилцуулгын хүрээнд хийлээ.

Үнэлгээнд хуулийн төсөл, үзэл баримтлалаас гадна статистик тоон үзүүлэлтүүд, тайлан мэдээлэл, холбогдох хууль тогтоомж, тэдгээрийн албан ёсны болон албан бус тайлбарууд болон хуулийн төслийн хэлэлцүүлгийн явцад гарсан санал зэрэг нэмэлт материалыг ашигласан болно.

Хуулийн төсөл нь дэвшүүлсэн зорилгоо хангасан эсэх, практикт хэрэгжих боломжтой эсэх, бусад хуулиудтай хэрхэн уялдсан, хуулийн төслийн найруулга, хэл зүй ойлгомжтой эсэх гэсэн шалгуур үзүүлэлт тус бүрийн дагуу хийсэн үнэлэлтийг нэгтгэн дараах **Дүгнэлтийг** хийж, **Зөвлөмж** боловсрууллаа:

Дүгнэлт:

- **Зорилгод хүрэх байдал:** Хуулийн төсөл нь үзэл баримтлалд тусгагдсан зорилтуудыг хангахад чиглэсэн, холбогдох зохицуулалтыг тусгасан байна.
- **Практикт хэрэгжих боломжийг хангасан байдал:** Хуулийн төсөлд Олон улсын гэрээ конвенцод заасан иргэний үндсэн эрхийг хамгаалах, Үндсэн

хуулийн өөрчлөлтийн агуулга, зарчимд нийцсэн газрын хэвлийн баялгийг ашиглахтай холбоотой байгаль орчны нөлөөллийг иргэн мэдэх эрхтэй байх зохицуулалтыг хөхүүлэн дэмжсэн байна.

- **Ойлгомжтой байдал:** Хуулийн төсөл нь Хууль тогтоомжийн тухай хуулийн 23, 28, 29, 30 дугаар зүйл, Хууль тогтоомжийн төсөл боловсруулах аргачлалд заасан шаардлагыг хангасан хэлбэрээ боловсруулагдсан ойлгомжтой байна.
- **Харилцан уялдааг хангасан байдал:** Хуулийн төслийн зүйл заалт өөр хоорондоо болон Үндсэн хуультай зарчмын хувьд зөрчилдөөгүй, үүрэг хүлээсэн байгууллага, албан тушаалтны чиг үүрэгт давхардал үүсгээгүй байна.

АШИГЛАСАН МАТЕРИАЛЫН ЖАГСААЛТ

1. Байгаль орчныг хамгаалах тухай хууль, Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төсөл. 2020 он. БОАЖЯ
2. Хуулийн төслийн үзэл баримтлал, танилцуулга. 2020 он. БОАЖЯ
3. Хуулийн төсөлд холбогдох байгууллагуудаас ирүүлсэн санал. 2020 он. БОАЖЯ
4. Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт хийсэн үнэлгээний тайлан. 2018 он.
5. Хуулийн төслийн зардлын тооцооны тайлан. 2020 он

Хууль тогтоомж, Засгийн газрын тогтоол, тушаалын жагсаалт

1. Монгол Улсын Үндсэн хууль;
2. Хууль тогтоомжийн тухай хууль;
3. Байгаль орчныг хамгаалах тухай хууль;
4. Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль;
5. Монгол Улсын Засгийн газрын тухай хууль;
6. Эрүүгийн хууль;
7. Зөрчлийн тухай хууль;
8. Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоол.
9. Биологийн олон янз байдлын тухай конвенци (1993-09-30)
10. Төрөөс экологийн талаар баримтлах бодлого (УИХ-ын 1997-12-26 дугаар 106)

--- оОо ---

БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСӨЛ

хуулийн иргэний эрх, үүрэгтэй холбоотой зохицуулалтын
хэрэгжилтийн үр дагаварт хийсэн үнэлгээний тайлан

Байгаль орчин, аялал жуулчлалын яам
2020 он.

Судалгааг гүйцэтгэсэн:

БОАЖЯ-ны Хүрээлэн буй орчин, байгалийн нөөцийн удирдлагын газрын
Байгаль орчны үнэлгээ, аудитын хэлтэс

БОАЖЯ-ны Төрийн захиргааны удирдлагын газрын Хуулийн хэлтэс

АГУУЛГА:

Товчилсон үг	1
Нэг. Төлөвлөх үе шат	2
1.1. Үнэлгээ хийх шалтгаан	2
1.2. Үнэлгээний хийх хүрээ	3
1.3. Үнэлгээний шалгуур үзүүлэлт	4
1.4. Үнэлгээний харьцуулах хэлбэр	4
1.5. Шалгуур үзүүлэлтийг томъёолох	4
1.6. Мэдээлэл цуглуулах	4
Хоёр. Хэрэгжүүлэх үе шат	5
Гурав. Үнэлэх үе шат	6
Дөрөв. Дүгнэлт, зөвлөмж	17
4.1. Үнэлэлт, дүгнэлт	17
4.2. Зөвлөмж	17
Ашигласан эх сурвалж	

НЭГ. ТӨЛӨВЛӨХ ҮЕ ШАТ

Байгаль орчныг хамгаалах тухай, Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн хэрэгжилтийн үр дагаварт Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолоор баталсан “Хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийх аргачлал”-ын дагуу үнэлгээ хийв.

Төлөвлөх үе шат нь үнэлгээ хийх ажлын суурь бөгөөд үүнд хамаарах алхмуудыг амжилттай гүйцэтгэж чадвал “хэрэгжүүлэх” болон “үнэлэх” үе шатанд хийх ажил илүү тодорхой болно.

Төлөвлөх шатны зорилго нь үнэлгээ хийх хүрээг тогтоож түүнд тохирсон шалгуур үзүүлэлтийг тодорхойлоход чиглэгдэнэ. Энэ үе шатанд дараахь алхмуудыг хийж гүйцэтгэнэ. Үүнд:

- Үнэлгээ хийх шалтгааныг тодорхойлох,
- Үнэлгээ хийх хүрээг тогтоох,
- Шалгуур үзүүлэлтийг сонгож тогтоох,
- Харьцуулах хэлбэрийг сонгох,
- Шалгуур үзүүлэлтийг томъёолох,
- Мэдээлэл цуглуулах аргыг сонгох

1.1. Үнэлгээ хийх шалтгаан

Ардчилсан Үндсэн хууль буюу 1992 оны Үндсэн хуулийн зорилго, зарчим, агуулгад нийцүүлж 1995 онд Байгаль орчныг хамгаалах тухай хуулийг баталсан. Энэ хууль нь байгаль орчны салбарын суурь хууль юм.

Уг хуульд 1998 оноос хойш 24 удаа нэмэлт, өөрчлөлт орж улам баяжуулж, хийдэл, давхардал, зөрчлийг нь арилгасаар ирсэн.

Байгаль орчныг хамгаалах тухай хууль нь энэ салбарын ерөнхий суурь хууль бөгөөд 9 бүлэг, 59 зүйлээс бүрддэг.


Уг хуулиар газар, түүний хөрс, газрын хэвлий, түүний баялаг, ус, ургамал, амьтан, агаар гэсэн объектыг хэрхэн хамгаалах, зохистой ашиглах, байгаль орчны тэнцлийг хадгалах зэрэг суурь харилцааг зохицуулдаг.

Харин Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийг 1998 онд анх баталж, 2012 онд шинэчилсэн найруулга хийж дахин баталсан. Энэ хуулинд 2012 оноос хойш 2 удаа нэмэлт, өөрчлөлт оруулсан.

Энэхүү хууль нь 5 бүлэг, 20 зүйлээс бүрддэг бөгөөд байгаль орчныг хамгаалах, хүний үйл ажиллагааны улмаас байгаль орчны тэнцвэрт байдал алдагдахаас сэргийлэх, байгаль орчинд сөрөг нөлөөлөл багатайгаар байгалийн нөөц ашиглалт явуулах, бүс нутаг, салбарын хэмжээнд баримтлах бодлого, хэрэгжүүлэх хөгжлийн хөтөлбөр, төлөвлөгөө болон аливаа төслийн байгаль орчинд нөлөөлөх байдлыг үнэлэх, хэрэгжүүлэх эсэх талаар дүгнэлт, шийдвэр гаргах, оролцогч талуудын харилцааг зохицуулдаг.

Зураг 1. Байгаль орчныг хамгаалах тухай, Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуульд нэмэлт оруулах хуулийн төсийн хэрэгцээ, шаардлага (судалгаанд оролцогчдын дүнд эзлэх хувиар)

график



■ Хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах шаардлагатай * Хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах шаардлагагүй
 ■ сайн мэдэхгүй УИХ шийдэх ёстой

1.2. Үнэлгээ хийх хүрээ

Үнэлгээ хийх хүрээг тогтоох зорилгоор хуулийн үйлчлэлд хамаардаг зарим субъектээс тодруулга, санал, хүсэлт зэргийг тодруулахад оролцогчдын дийлэнх олонхын саналаар Үндсэн хуулийн өөрчлөлтийг салбар хуулиар баталгаажуулах, баяжуулах, иргэдийн эрхийг баталгаажуулах ёстой гэж үзсэн.

Үүнийг харгалзан Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 4, 16, 17 дугаар зүйл, Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн 14, 18 дугаар зүйлд нэмэлт оруулж иргэд газрын хэвлийн баялгийг ашигласнаас үүдэх байгаль орчны нөлөөллийг мэдэх эрхтэй байх нь зүйтэй гэж үзсэн.

1.3. Үнэлгээний шалгуур үзүүлэлт

Хуулиудын хэрэгжилтийн судалгаанд нэгдүгээрт: зорилгод хүрсэн түвшин, хоёрдугаарт: практикт нийцэж байгаа байдал гэсэн хоёр шалгуур үзүүлэлтийг сонгосон болно.

Зорилгод хүрсэн түвшин: Байгаль орчныг хамгаалах тухай, Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль тогтоомжид байгалийн баялгийг ашиглахаас өмнө болон ашиглах явцад байгаль орчинд үзүүлэх нөлөөлөл, түүнийг бууруулах талаар олон нийтийн оролцоог хангах, төслийн нөлөөлөлд өртөх иргэдэд байгаль орчны талаар мэдээлэл өгөх, мэдээллээр хангах асуудлыг нарийвчлан зохицуулсан байна.

Тухайлбал: Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 4 дүгээр зүйлд иргэний эрх, үүргийг тодорхой заасан, хуулийн 15-17 дугаар зүйлд салбар яам, нутгийн өөрөө удирдах байгууллага, Засаг дарга нар иргэдийг мэдээллээр хангах асуудлыг тусгасан, мөн хуулийн 7 дугаар бүлэг буюу 33-44 дүгээр зүйл хүртэл Байгаль орчны мэдээллийн сангийн харилцааг зохицуулсан. Энэхүү мэдээллийн сан нь улсын хэмжээнд өргөн хэрэглэдэг нэгдсэн мэдээллийн бааз болж чадсан бөгөөд иргэд, аж ахуйн нэгж, байгууллагууд шаардлагатай мэдээллээ уг сангаас авч үйл ажиллагаандаа ашиглаж байна.

Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуульд байгаль орчны нөлөөллийн ерөнхий болон нарийвчилсан үнэлгээнд иргэдийн оролцоог тусгах, санал, хүсэлтийг нь авах, орон нутгийн байгууллагын санал, шүүмжлэлийг тусгах, байгаль орчинд учрах сөрөг нөлөөллийг бууруулах арга замыг тодорхой болгох, нөхөн сэргээлтийн хийх төлөвлөгөө, байгаль орчинд ээлтэй технологийн шийдэл зэргийг оруулдаг байна.

Практикт нийцэж байгаа байдал: Байгаль орчны салбарын хууль тогтоомжид иргэдийн мэдэх эрхийг харьцангуй сайн хуульчилсан бөгөөд улсын хэмжээнд Байгаль орчны мэдээллийн сан ажиллуулж байна. Энэ нь Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн нэг бүлэг болж зохицуулагддаг бөгөөд практикт сайн хэрэгжиж байна. Байгаль орчныг хамгаалах тухай хууль нь салбарын суурь хууль учраас салбар хууль болох БОНБҮТХуульд ч энэ асуудлыг тусгаж байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээнүүдэд байгаль орчны асуудлын талаарх мэдээллүүдийг заавал тусгахаар зохицуулсан байна.

ХОЁР. ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЕ ШАТ

Хуульд нэмэлт оруулах төслийг боловсруулах ажилд бэлэн байгаа мэдээллийг цуглуулах болон холбогдох субъектээс судалгаа авах аргаар шаардлагатай мэдээллийг цуглуулах.

Нэг. Бэлэн байгаа мэдээлэл

Эрх зүйн баримт бичиг

1. Монгол Улсын Үндсэн хууль;
2. Хууль тогтоомжийн тухай хууль;
3. Байгаль орчныг хамгаалах тухай хууль;

4. Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль

Хоёр. Судалгааны аргаар цуглуулсан мэдээлэл

Хуулийн хэрэгжилтийн өнөөгийн байдалд дүн шинжилгээ хийх, мэдээллийн эх үүсвэр болгох үүднээс Байгаль орчин, аялал жуулчлалын яамнаас 2017 онд Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн хэрэгжилтэд хийсэн тайланг үндэслэл болгов.

ГУРАВ. ҮНЭЛЭХ ҮЕ ШАТ

Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 4, 16, 17 дугаар зүйл, Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн 14, 18 дугаар зүйлд нэмэлт оруулж иргэд газрын хэвлийн баялгийг ашигласнаас үүдэх байгаль орчны нөлөөллийг мэдэх эрхийг баталгаажуулж өгсөн. Үүнд:

Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 4 дүгээр зүйлийн иргэний эрх, үүргийн зохицуулалтад нэмэлт оруулах, хуулийн 16, 17 дугаар зүйлд заасан ИТХ, Засаг дарга нарын эрх, үүрэгт нэмэлт оруулах, Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн 14 дүгээр зүйлд заасан төсөл хэрэгжүүлэгчийн үүрэгт нэмэлт оруулах, 18 дугаар зүйлд заасан олон нийтийн оролцооны зохицуулалтад тус тус нэмэлт оруулахаар байна.

ДӨРӨВ. ДҮГНЭЛТ

Байгаль орчныг хамгаалах тухай, Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль тогтоомжид байгалийн баялгийг ашиглахаас өмнө болон ашиглах явцад байгаль орчинд үзүүлэх нөлөөлөл, түүнийг бууруулах талаар олон нийтийн оролцоог хангах, төслийн нөлөөлөлд өртөх иргэдэд байгаль орчны талаар мэдээлэл өгөх, мэдээллээр хангах асуудлыг нарийвчлан зохицуулсан байна.

Тухайлбал: Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 4 дүгээр зүйлд иргэний эрх, үүргийг тодорхой заасан, хуулийн 15-17 дугаар зүйлд салбарын яам, нутгийн өөрөө удирдах байгууллага, Засаг дарга нар иргэдийг мэдээллээр хангах асуудлыг тусгасан, мөн хуулийн 7 дугаар бүлэг буюу 33-44 дүгээр зүйл хүртэл Байгаль орчны мэдээллийн сангийн харилцааг зохицуулсан. Энэхүү мэдээллийн сан нь улсын хэмжээнд өргөн хэрэглэдэг нэгдсэн мэдээллийн бааз болж чадсан бөгөөд иргэд, аж ахуйн нэгж, байгууллагууд шаардлагатай мэдээллээ уг сангаас авч үйл ажиллагаандаа ашиглах асуудлыг зохицуулсан байна. Тухайлбал:

1. Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 4 дүгээр зүйлд иргэний дараах эрхийг хуульчилсан:

1/гэм буруутай этгээд байгаль орчинд хортой нөлөөлснөөс эрүүл мэнд, эд хөрөнгөндөө учирсан хохирлыг түүгээр нөхөн төлүүлэхээр нэхэмжлэх;

2/байгаль орчныг хамгаалах тухай хууль тогтоомжийн зөрчилтэй тэмцэх болон байгаль орчинд хортой нөлөөлсөн этгээдэд хариуцлага хүлээлгэхийг шаардах, байгаль орчинд учруулсан хохирлыг барагдуулахаар шүүхэд нэхэмжлэл гаргах;

3/байгаль орчныг хамгаалах олон нийтийн байгууллага байгуулах, хөрөнгийн сан үүсгэх нутгийн иргэд сайн дурын үндсэн дээр нэгдэж байгалийн баялгийг арчлан хамгаалах, нөхөн сэргээх, түүний ашиг шимийг хүртэх;

4/холбогдох байгууллагаас байгаль орчны тухай үнэн, зөв мэдээлэл авах;

5/байгалийн нөөц, баялгийн халдашгүй байдлыг хангах, байгаль орчинд хортой нөлөөлөх аливаа үйл ажиллагааг хязгаарлах, таслан зогсоох шийдвэр гаргахыг болон байгаль орчинд хортой нөлөөлж болзошгүй аж ахуйн нэгж, байгууллагыг шинээр байгуулах зөвшөөрөл олгохгүй байхыг холбогдох эрх бүхий байгууллагаас шаардах;

6/сайн дурын үндсэн дээр зохион байгуулалтад орж, энэ хуулийн 3 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 8 дахь заалтад заасан нөхөрлөл байгуулах замаар оршин суугаа нутгийнхаа байгалийн тодорхой төрлийн баялгийг хамгаалах, холбогдох хууль тогтоомжийн дагуу гэрээгээр ашиглах, эзэмших гэж тус тус заажээ.

2.Хуулийн 15 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 6/-д Төрийн захиргааны төв байгууллага нь байгаль орчны тухай мэдээллээр иргэн, аж ахуйн нэгж, байгууллагыг хангах биологийн болон генетикийн нөөцийг тогтвортой ашиглахад чиглэгдсэн уламжлалт мэдлэг, шинэ санаа, амьдралын туршлагыг хэрэглэснээр гарах үр ашгийг тэгш, шударгаар ашиглах явдлыг дэмжих гэж, 15 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 15/-д байгаль орчны мэдээллийн сангийн үйл ажиллагааны талаархи хууль тогтоомжийг хэрэгжүүлэх ажлыг нэгдсэн удирдлагаар хангаж, хэрэгжилтэд нь хяналт тавих гэж тус тус заасан.

3.Хуулийн 7 дугаар бүлэгт Байгаль орчны мэдээллийн санг зохицуулж мэдээллийн сангийн хэлбэр, тогтолцоо, бүрдэл, мета мэдээллийн сан, байгаль орчин учруулсан хохиролын мэдээллийн сан, мэдээлэл төвлөрүүлэх байгууллагын үүрэг, хугацаа, мэдээллийн сангийн эрх үүрэг, зэргийг хуульчилсан байна.

Харин Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуульд байгаль орчны нөлөөллийн ерөнхий болон нарийвчилсан үнэлгээнд иргэдийн оролцоог тусгах, санал, хүсэлтийг нь авах, орон нутгийн байгууллагын санал, шүүмжлэлийг тусгах, байгаль орчинд учрах сөрөг нөлөөллийг бууруулах арга замыг тодорхой болгох, нөхөн сэргээлт хийх төлөвлөгөө, байгаль орчинд ээлтэй технологийн шийдэл зэргийг хуульчилсан зэрэг давуу талтай байна.

Гэсэн хэдий ч байгалийн баялгийн ашиглалт тэр дундаа газрын хэвлийн баялгийн ашиглалтын талаар иргэний мэдэх эрх зайлшгүй хуульчлагдаж баталгаажих ёстой гэж үзэн Үндсэн хуулийн өөрчлөлтийн агуулгад нийцүүлж иргэн эрүүл, аюулгүй орчинд амьдрах эрхийнхээ хүрээнд газрын хэвлийн баялгийн ашиглалтаас үүдэх байгаль орчны нөлөөллийн талаар иргэний мэдэх эрхийг хангах нарийвчилсан зохицуулалтыг хуульд тусгах шаардлагатай гэж үзлээ.

**БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ
ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ
ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН ЗАРДЛЫН
ТООЦООНЫ ТАЙЛАН**

**Байгаль орчин, аялал жуулчлалын яам
2021 он**

**БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ХУУЛЬД
НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСЛИЙН
ЗАРДЛЫН ТООЦООНЫ ТАЙЛАН**

Хуулийн төслийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлыг Засгийн газрын 2016 оны 59 дүгээр тогтоолын 4 дүгээр хавсралтаар батлагдсан “Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоо хийх аргачлал” /цаашид “аргачлал” гэх/-ын дагуу тооцлоо.

Уг аргачлалд заасан журмын дагуу зардлыг төрийн байгууллагын зардал, хуулийн этгээдийн зардал, иргэнд үүсэх зардал гэсэн гурван төрлөөр тооцдог.

Хуулийн төслөөр аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга нарт нэмэлт үүрэг хүлээлгэж, иргэний мэдэх эрхтэй холбоотой эрхийг нэмэгдүүлж байгаа бөгөөд үүнтэй холбоотойгоор улсын болон орон нутгийн төсөв, иргэнд ямар нэг нэмэлт зардал бий болохгүй юм.

Хууль тогтоомжийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлыг тооцоход дор дурдсан нийтлэг зарчмыг баримтлан ажилласан. Үүнд:

- Хуулийн этгээд, иргэн, төрийн байгууллагын гүйцэтгэх үүрэг нэг бүрийг оновчтой тодорхойлох;
- Үүрэг гүйцэтгэхэд зарцуулах хугацааг тогтооход бодитой хандах;
- Бодит тоо баримт, мэдээлэлд тулгуурлах;
- Аргачлалд заасан тооцоо хийх үе шатыг баримтлах.

Нэг. Байгаль орчныг хамгаалах тухай, Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуульд нэмэлт оруулах тухай хуулийн төсөл батлагдсанаар төрийн байгууллага буюу улсын төсөвт үүсэх зардал

Төсөлд төрийн байгууллага буюу улсын төсөвт үүсэх зардлыг тухайн ажил үйлчилгээг гүйцэтгэхэд шаардагдах хүний нөөцийн хэрэгцээг тодорхойлсны үндсэн дээр нэг албан хаагчид шаардагдах зардлаар үржүүлэн тооцох замаар дараахь үе шаттайгаар гаргалаа. Үүнд:

1. Хуулийн төсөлд тусгагдсан төрийн байгууллагын гүйцэтгэх үүрэг буюу ажил, үйлчилгээ нэг бүрийг тодорхойлох;
2. Ажил, үйлчилгээг гүйцэтгэх хугацааг тодорхойлсны үндсэн дээр шаардлагатай хүний нөөцийг хэрэгцээг тогтоох;
3. Хүний нөөцтэй холбоотой гарах зардлыг урьдчилан тооцох; /хүний нөөцийн хэрэгцээ тогтоогдсон тохиолдолд/
4. Бусад зардал буюу материаллаг зардлыг нэгтгэн тооцох; /хүний нөөцийн хэрэгцээ тогтоогдсон тохиолдолд/
5. Хувилбарыг нягтлах. /хүний нөөцийн хэрэгцээ тогтоогдсон тохиолдолд/

Хуулийн төсөлд тусгагдсан төрийн байгууллагуудын гүйцэтгэх үүрэг буюу ажил үйлчилгээг нэг бүрчлэн түүвэрлэн, хийж гүйцэтгэх үйл явцын дагуу уялдаа холбоог харгалзан тодорхойлсон.

Ийнхүү тодорхойлохдоо ажил үйлчилгээнд хэрэгжүүлэх, хэмжих боломжтой ажлыг хамааруулах нь зүйтэй.

Үйл ажиллагаа тус бүрт зарцуулах хугацааг тооцохдоо төрийн байгууллагад хийгддэг адил төстэй үйлчилгээг судалж, холбогдох мэргэжилтнүүдийн ажилбарт ажлын байрны зураг авалтын үр дүнд гаргасан хугацаан дээр үндэслэн тэдгээрийн гүйцэтгэх хугацааг тодорхойлон тооцлоо.

Шаардагдах ажлын цагийг Хөдөлмөрийн тухай хуульд тусгагдсан ажиллах цагийн горимтой харьцуулан авч үзнэ. Ингэхдээ нэг жилд ажиллах өдөр, цаг, минут гэсэн хэмжигдэхүүнд тулгуурлана.

1 жил = ажлын 200¹ өдөр

1 өдөр = ажлын 8 цаг /хөдөлмөрийн хуулийн дагуу/

1 цаг = ажлын 60 минут

Жилд 200 ажлын өдөр буюу /200 х 8/ 1600 ажлын цаг буюу /1,600 х 60/ 96000 минут ажиллана гэсэн үг.

Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга:

Байгаль орчныг хамгаалах тухай хуульд нэмэлт оруулах хуулийн төслөөс:

1 дүгээр зүйл. Байгаль орчныг хамгаалах тухай хуульд доор дурдсан агуулгатай дараах заалт нэмсүгэй:

1/4 дүгээр зүйлийн 1 дэх хэсгийн 7 дахь заалт:

“7/тухайн нутаг дэвсгэрийн хүрээнд газрын хэвлийн баялгийн ашиглалтын нөхцөл байдал, байгаль орчинд үзүүлж байгаа нөлөөлөл, нөхөн сэргээлт болон эрх бүхий байгууллагаас хяналтын чиглэлээр хэрэгжүүлж байгаа арга хэмжээний талаар мэдэх.”

2/16 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 11 дэх заалт:

“11/харьяа нутаг дэвсгэрийн хүрээнд газрын хэвлийн баялгийг ашиглалтын нөхцөл байдал, байгаль орчинд үзүүлж байгаа нөлөөлөл, нөхөн сэргээлт болон хяналтын чиглэлээр хэрэгжүүлсэн арга хэмжээний талаар иргэдэд нээлттэй мэдээлэх, байгаль орчны төлөв байдлын мэдээлэлд тусгаж, иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд тайлагнах.”

¹Хуанлийн 365 хоногоос хөдөлмөрийн хуулинд заасан нийтээр амрах байрын өдөр, ээлжийн амралт, хагас бүтэн сайн өдөр зэргийг хасаж бодитой ажиллах өдрийг тооцно.

3/17 дугаар зүйлийн 2 дахь хэсгийн 11 дэх заалт:

“11/харьяа нутаг дэвсгэрийн хүрээнд газрын хэвлийн баялгийг ашиглалтын нөхцөл байдал, байгаль орчинд үзүүлж байгаа нөлөөлөл, нөхөн сэргээлт болон хяналтын чиглэлээр хэрэгжүүлсэн арга хэмжээний талаар иргэдэд нээлттэй мэдээлэх, газрын хэвлийн баялгийн ашиглалтын талаар байгаль орчны төлөв байдлын мэдээлэлд тусгаж, иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд тайлагнах.”

Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга нь дээрх зүйлд тусгагдсан үйл ажиллагааг зохион байгуулах ажлыг жилдээ 2 удаа гүйцэтгэх тул аргачлалын дагуу тохиолдлын давтамжийг үйл ажиллагаанаас хамаарч харилцан адилгүй тогтоолоо.

Мэдээлэх үүрэг	Агуулга	Стандарт үйл ажиллагаа	Зарцуулах хугацаа	Тохиолдлын тоо	Тоон үзүүлэлт /мин
Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга нар иргэдийг мэдээллээр хангана.	Газрын хэвлийн баялагийн ашиглалттай холбоотой мэдээлэл бий болгох	мэдээлэл цуглуулах	5 өдөр /40цаг/ 2400 мин	0,2 ²	480
		танилцах, мэдээллээ үнэлэх	3 өдөр /24 цаг/ 1440 мин	0,2	240
		нягтлах	2 өдөр /8цаг/ 480 мин	0,2	96
		хянах	2 өдөр /8цаг/ 480 мин	0,2	96
	тухай шатны иргэдийн төлөөлөгчдийн хуралд танилцуулах	мэдээлэлээ танилцуулах	5 өдөр /40цаг/ 2400 мин	0,2	480
		нягтлах	3 өдөр /24цаг/ 1440 мин	0,2	240
		Батлах, албажуулах	0,5 өдөр /4 цаг/ 240 мин	0,2	48
		Мэдээлэл ил тод нээлттэй болгох	2 өдөр /16цаг/ 960 мин	0,2	192
	Иргэдийг мэдээллээр хангах ажлыг зохион байгуулах, хэрэгжилтийг хянах	Хэрэгжилтийн талаарх мэдээлэл цуглуулах	5 өдөр /40цаг/ 2400 мин	1	2400
		танилцах, мэдээллээ үнэлэх	5 өдөр /40цаг/ 2400 мин	1	2400
		нягтлах	3 өдөр /24цаг/ 1440 мин	1	1440
		боловсруулах	3 өдөр /24цаг/ 1440 мин	1	1440
Засаг дарга нар мэдээллээ	Арга хэмжээний тайлан хүргүүлэх	Хэрэгжилтийн талаарх	5 өдөр /40цаг/ 2400 мин	1	2400

² Тус үйл ажиллагааг 5 жил тутамд хэрэгжүүлэх тул тохиолдлын тоог 0,2 гэж тооцлоо.

холбогдох ЗГХЭГ, холбогдох яам, агентлагт хүргүүлж мэдээлэл солилцох	мэдээлэл цуглуулах			
	танилцах, мэдээллээ үнэлэх	5 өдөр /40цаг/ 2400 мин	1	2400
	Хэрэгжилтийн талаарх боловсруулсан мэдээллийн нягтлах	5 өдөр /40цаг/ 2400 мин	1	2400
	Тайланг хүргүүлэх	2 өдөр /8цаг/ 480 мин	1	960
				17712

Ийнхүү үйл ажиллагаа тус бүрт зарцуулах хугацааг нэгтгэн шаардагдах нийт ажлын цагийг гаргаж уг ажлын цагт ажиллах хүний нөөцийн хэрэгцээг дараахь байдлаар гаргалаа.

Нэгж	Хүний нөөцийн хэрэгцээ	Жилд шаардагдах ажлын цаг/мин	Нэмэгдэж буй ачаалал /орон тоо/
Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал болон Засаг даргын Тамгын газар	17712 мин	96000	0.18

Аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг даргын Тамгын газар нь нутаг дэвсгэртээ байгаль орчны хууль тогтоомжийг хэрэгжүүлэх, байгаль орчныг хамгаалах байгалийн баялгийг зохистой ашиглах, учирсан хохирлыг арилгуулах зэрэг үйл ажиллагааг хэрэгжүүлэх чиг үүргийг гүйцэтгэхэд 11712 цагийн ачаалал үүсч байгаа бөгөөд энэ нь тухайн ажлыг хийж гүйцэтгэхэд 0,18 хүн шаардлагатай гэсэн тооцоолол гаргалаа. Өөрөөр хэлбэл уг ажлыг хариуцсан орон тоо гаргах шаардлагагүй бөгөөд одоо ажиллаж байгаа албан хаагчаар хариуцан гүйцэтгүүлэх боломжтой юм.

Хуулийн этгээдэд үүсэх зардал

Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуульд нэмэлт оруулах хуулийн төслөөс:

1 дүгээр зүйл. Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуульд доор дурдсан агуулгатай дараах хэсэг, заалт нэмсүгэй:

1/18 дугаар зүйлийн 18.5, 18.6, 18.7 дахь хэсэг:

“18.5.Иргэн тухайн нутаг дэвсгэрийн хүрээнд газрын хэвлийн баялгийн ашиглалтын нөхцөл байдал, байгаль орчинд үзүүлж байгаа нөлөөлөл, нөхөн сэргээлт болон төрийн эрх бүхий байгууллагаас хяналтын чиглэлээр хэрэгжүүлж байгаа арга хэмжээний талаар мэдээлэл авах хүсэлтийг аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг даргад гаргана.

18.6.Засаг дарга иргэний энэ хуулийн 18.5-д заасан хүсэлтийн дагуу холбогдох мэдээллийг Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийн 14.8-д заасан хугацаанд гаргаж өгөх үүрэгтэй.

18.7.Иргэн үйл ажиллагаатай нь холбогдуулан газрын хэвлийн баялгийн ашиглалтын нөхцөл байдал, байгаль орчинд үзүүлж байгаа нөлөөлөл, нөхөн сэргээлтийн талаарх мэдээлэл авах, танилцах боломж олгох хүсэлтийг төсөл хэрэгжүүлэгчид гаргаж болно.”

2/14 дүгээр зүйлийн 14.1.4 дэх заалт:

“14.1.4.иргэний хүсэлтийн дагуу өөрийн үйл ажиллагаатай холбоотой газрын хэвлийн баялгийг ашиглалтын нөхцөл байдал, байгаль орчинд үзүүлж байгаа нөлөөлөл, нөхөн сэргээлтийн явц, үр дүнгийн талаарх мэдээлэл өгөх, эсхүл танилцах боломжоор хангах үүрэгтэй.”

2 дугаар зүйл.Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийн 18 дугаар зүйлийн 18.5 дахь хэсгийн дугаарыг “18.8” гэж өөрчилсүгэй.

3 дугаар зүйл.Энэ хуулийг Байгаль орчныг хамгаалах тухай хуульд нэмэлт оруулах тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Байгаль орчныг хамгаалах хууль тогтоомжоор хуулийн этгээд буюу төсөл хэрэгжүүлэгч нь Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээг өөрсдийн зардлаар хийлгэдэг бөгөөд хуульд энэхүү нэмэлт заалт орсноор хуулийн этгээдэд санхүүгийн нэмэлт зардал үүсэхгүй юм.

ДҮГНЭЛТ:

Хуулийн төслөөр аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга нар, тэдний Тамгын газрын үйл ажиллагааны зардал, хүний нөөцийн хэрэгцээ шаардлагыг тооцлоо.

Тооцооллоос үзэхэд аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга нарт хүний нөөцийн нэмэлт хэрэгцээ шаардлага үүсэхгүй гэсэн тооцоол гарсан.

Хүний нөөцийн хэрэгцээ шаардлага үүсээгүй тул хүний нөөцтэй холбоотой гарах зардлыг урьдчилан тооцох болон хувилбарыг нягтлах шаардлагагүй байна.

--- оОо ---

**БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ТУХАЙ, БАЙГАЛЬ ОРЧИНД НӨЛӨӨЛӨХ
БАЙДЛЫН ҮНЭЛГЭЭНИЙ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ ХУУЛИЙН ТӨСӨЛД
БАЙГАЛЬ ОРЧНЫ ҮНЭЛГЭЭ ЭРХЛЭГЧДИЙН ХОЛБОО ТӨРИЙН БУС
БАЙГУУЛЛАГААС ИРҮҮЛСЭН САНАЛЫН ТОВЬЁОГ**

2021.09.03

Д/д	Хуулийн заалтыг өөрчлөх шалтгаан	Одоо хэрэгжиж буй хуулийн заалт	Хуулийн заалтыг өөрчлөх санал	Тайлбар
1	Олон улсын жишгээр бол төсөл хэрэгжүүлэгч хэрэгжүүлэх төслийнхээ баримт бичгүүдийг ЛЭЗУ, зураг төсөл г.м/ боловсруулахын тулд байгаль орчны төлөв байдлын үнэлгээ /БОТБУ/-г хийлгэдэг. Үүнийг үндэслэн баримт бичгүүдээ боловсруулдаг. Энэ жишгээр явахын тулд БОНБУТХ-д үнэлгээний талаар 2012 онд оруулсан боловч уг үнэлгээг баримт бичиг боловсруулах явцад хийнэ гэж оруулсан нь цаг хугацааны хувьд хоцорч хийгдэх, төсөл хэрэгжүүлэгч нарт ач холбогдол багатай баримт бичиг болж байгаа юм.	3.1.4 "байгаль орчны төлөв байдлын үнэлгээ" гэж аливаа төслийн техник, эдийн засгийн төлөвлөлтөийн баримт бичиг, зураг төсөл, улсын болон бүс нутаг, салбарын хэмжээнд хэрэгжүүлэх хөгжлийн хөтөлбөр, төлөвлөгөөг боловсруулах явцад тэдгээрийг хэрэгжүүлэх нутаг дэвсгэрийн байгаль орчны төлөв байдлыг судлан тогтоож цаашид төсөл, хөтөлбөр, төлөвлөгөө, бодлого боловсруулахад анхаарах байгалийн нөхцөл, орчны онцлогийг тодорхойлохыг.	Уг заалтын "боловсруулах явцад" гэснийг "боловсруулахын тулд" гэж өөрчлөх, мөн "цаашид" гэдгийг хасах Мөн "БОТБУ нь төсөл, хөтөлбөр, төлөвлөгөө боловсруулах үндсэн тулгуур баримт бичиг болно" гэсэн заалтыг нэмж оруулж өгөх хэрэгтэй байна.	1. "Байгаль орчны үнэлгээ эрхлэгчдийн холбоо" ТББ-аас ирүүлсэн санал нь хуулийн төслийн үзэл баримтлалд шууд хамааралгүй байсан тул саналыг тусгаагүй болно. Тухайн ТББ-аас ирүүлсэн санал нь Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хуулийг боловсронгуй болгох талаар гаргасан ерөнхий саналууд бөгөөд цаашид тухай хуулийг сайжруулахад саналыг тусгахаар төлөвлөж байна. Хуулийн төсөл боловсруулах ажлыг хэсэгт уг ТББ-ын төлөөллийг оролцуулж хамтран ажилласан бөгөөд хуулийн төслийн
	БОТБУ нь их чанар муутай, бүс нутгийн байгаль орчны ерөнхий мэдээллийг хуулсан баримт бичиг болж хувирсан нь байгаль орчны талаар зохих мэдлэгтэй хүмүүст тодорхой байгаа. БОНБУТХ-ийн 6.6 –д хянах заалттай ч хангалттай хэрэгжихгүй байна.	6.6 Эрх бүхий мэргэжлийн байгууллага нь боловсруулсан байгаль орчны төлөв байдлын үнэлгээ болон хуримтлагдах нөлөөллийн үнэлгээний тайланг байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын дэргэдэх үнэлгээний асуудал эрхэлсэн мэргэжлийн зөвлөлд хүргүүлж хянуулна.	Нэгэнт БОТБУ-ний тайлангийн чанар муу байгаа тул сайжруулах үүднээс "үнэлгээний асуудал эрхэлсэн мэргэжлийн зөвлөлд хүргүүлж хянуулна." гэдгийн оронд "Шүүмж хийлгэж дүгнэлт гаргуулна" гэж оруулах	
	Хуримтлагдах нөлөөллийн үнэлгээний тодорхойлолтод байгаль орчин гэсэн заалт хаягдсан	3.1.5 "хуримтлагдах нөлөөллийн үнэлгээ" гэж	Уг заалтын дараах хэсгийг ".....төслүүдээс байгаль	

	<p>учраас уг үнэлгээний мөн чанарыг гажуудуулсан тодорхойлолт болсон.</p>	<p>тодорхой бүс нутаг, сав газарт иргэн, аж ахуйн нэгж, байгууллагаас хэрэгжүүлж байгаа төслүүдээс хүн амын эрүүл мэндэд үзүүлж байгаа хам болон давхардмал сөрөг нөлөөллийг тодорхойлж, түүнийг бууруулах, арилгах арга хэмжээ тогтоохыг;</p>	<p>орчин, хүн амын эрүүл мэндэд үзүүлж байгаа.....” гэж засварлах</p>	<p>эцсийн хувилбарыг танилцуулсан болно.</p>
	<p>8-р зүйлийн 8.4.2, 8.4.3 дахь заалтуудад “болзошгүй болон гол сөрөг нөлөөлөл” гэж төслийн нөлөөллийг заасан нь одоогоор олон улсын хэмжээнд хэрэгжиж буй байгаль орчны үнэлгээнүүдэд байхгүй болсон. Харин төслийн нөлөөллийн “Significance”-ийг үнэлж байгаа. Энэ нь төслийн эерэг ба сөрөг 2 талыг хоёуланг нь үнэлэх утгаар хэрэглэгддэг. Манайхан уг үгийг уршигт байдлыг үнэлэх гэж орчуулаад нэг талыг нь бариад явж байгаа.</p>	<p>8.4.2. төслийн болзошгүй болон гол сөрөг нөлөөлөл,.....</p>	<p>БОУ-гээр эерэг ба сөрөг нөлөөллүүдийг аль алиныг нь тодорхойлж үнэлэх ёстой. Нөгөө талаар нөлөөллийн “Significance”-ийг /чухал ач холбогдлыг/ үнэлж дүгнэх хэрэгтэй байгаа юм. Үнэлгээний энэ үндсэн ойлголтыг хуульд болон арга аргачлалдаа тодорхой тусгах хэрэгтэй байна. Ийм учраас хуулийн 8.4 дүгээр заалтад “төслийн эерэг ба сөрөг нөлөөллүүд, тэдгээрийн Significance/чухал ач холбогдлыг үнэлсэн дүгнэлт” гэж нэмж оруулах, мөн гол нөлөөлөл гэсэн нэр томъёог өөрчлөн найруулах</p>	
	<p>БОННУ-ний тайланг баг, дүүргийн ИНХ-аар хэлэлцүүлэх нь хүлээгдэл үүсгэдэг, иргэдийн зарим нь төслийн асуудалтай гүнзгий танилцахыг хүсдэггүй, улс төржүүлдэг, харддаг, сөрөг талаас нь үндэслэлгүй хэт үнэлдэг, ашиг хүртэх үүднээс ханддаг, нийтийг уриалдаг, хэт нэг талыг барих хандлага гаргадаг нь өнгөрсөн хугацаанд бүрэн тодорхой болсон.</p>	<p>8.4.8 төсөл хэрэгжих нутаг дэвсгэрийн захиргаа, төслийн нөлөөлөлд өртөх нутгийн иргэдийн нийтийн хурлын санал, тэмдэглэл;</p>	<p>Үүнийг хэрэгжүүлэхэд саналын давхардал үүсэх, нийтийн хурлын хүндрэл бэрхшээлтэй байдлыг үүсгэх зэргээс зайлсхийж, уг заалтыг хасаж, харин энэ хуулийн 18.4 дэх заалт /санал авах,</p>	

			<p>хэлэлцүүлэг зохион байгуулах/-ыг баримтлах нь олон нийтийн оролцоог хангах үндсэн арга хэрэгсэл болно. Олон улсын БОУ-нд баримталдаг практикт ч илүү дөхөмтэй юм.</p>
	<p>БОМТ-д дүйцүүлэн хамгаалал хийхийг заасан нь бүх төсөлд хамаарч байна. Энэ нь үндэслэлгүй юм.</p>	<p>9.6 Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөнд байгаль орчны нөлөөллийн үнэлгээгээр тогтоосон сөрөг нөлөөллийг багасгах, арилгах арга хэмжээ, дүйцүүлэн хамгаалал хийх, тэдгээрийг хэрэгжүүлэх хугацаа, шаардагдах хөрөнгө зардлыг тусгасан байна.</p>	<p>Дүйцүүлэн хамгаалал хийх гэсэн заалтыг шаардлагатай төслүүдэд хамааруулж ялгавартай зааж өгөх</p>
	<p>БОАЖЯ нь үндсэн чиг үүргийн бодлогын яамны үйл ажиллагааны зэрэгцээгээр бодлого хэрэгжүүлэх үйл ажиллагаанд хэт их оролцож бизнес эрхлэгч нарт чирэгдэл их учруулж байна. Энэ нь ерөнхий үнэлгээ хийсэн бүх төслүүдийн тухайн жилийн БОМТ-г батлах үйл ажиллагаагаар илэрч байна.</p> <p>БОМТ-г батлах, хянах, тайлагнах процессын үйл ажиллагааг төслийнх нь их бага, онцлогоос нь хамааруулаад орон нутагт /аймаг, нийслэл, сумд/ өгмөөр байна. Нэгэнт бодлогын яам БОННУ болон БОМТ-г батлаад гаргалаа. Үүнийг орон нутаг хэрэгжүүлэх боломжтой. БОМТ-ний хэрэгжилтийн мэдээллийг орон нутгаас авах боломжтой.</p> <p>Зарим стратегийн ач холбогдолтой, том төслүүдийг яамны хяналт дор байлгаж болох юм.</p>	<p>9.8.Байгаль орчны нөлөөллийн ерөнхий үнэлгээ хийсэн байгууллага төсөл хэрэгжүүлэгчийн тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийн тайланг жил бүрийн 12 дугаар сард багтаан хүлээн авч дараа оны төлөвлөгөө болон түүнийг хэрэгжүүлэхэд шаардагдах хөрөнгө, зардлын хэмжээг батална.</p>	<p>9.8 заалтын “Байгаль орчны нөлөөллийн ерөнхий үнэлгээ хийсэн байгууллага” гэдгийн оронд “аймаг, нийслэлийн байгаль орчны алба” гэж оруулах</p>
	<p>Уурхайн хаалтын асуудал нь өөрөө байгаль орчны асуудлаас гадна уурхайн болон орон нутгийн нийгэм, эдийн засгийн асуудлыг хамарсан, ТЭЗҮ, БОННУ зэрэгт тулгуурласан тусгай төсөл боловсруулсан байх ёстой. Түүнийг хэрэгжүүлэх хаалтын төлөвлөгөөтэй байх үндэслэлтэй юм. Ялангуяа томоохон төслүүдийн</p>	<p>14.1.3 газрын тос болон уул уурхайн төслүүд нь нөхөн сэргээлт, хаалтын менежментийн төлөвлөгөөг тухайн үйл ажиллагаа эхэлж, хаалт хийхээс гурван жилээс</p>	<p>Уурхайн хаалттай холбогдох заалтыг “Ашигт малтмалын тухай” хуульд маш тодорхой тусгаж өгөх шаардлагатай байна. Байгаль орчны яамны байгаль орчин, хүний эрүүл мэндийн</p>

	<p>хувьд маш их чухал. Гэтэл 14.1.3 дахь заалт хэрэгжихээргүй заалт юм. 3-хан жилийн өмнө хаалтын төлөвлөгөө хийгээд хуримтлал үүсгээгүй уурхай хаалт хийх чадваргүй болсон байх болно.</p>	<p>доошгүй хугацааны өмнө боловсруулж, тухайн салбарын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын саналыг авч, байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад ирүүлэх.</p>	<p>асуудлыг хуульдаа илүү тодорхой болгож өгмөөр байна. 14.1.3 “газрын тос болон уурхайн төслүүд нь хаалтын төсөл болон төлөвлөгөөг уурхайн үйл ажиллагааны эхний үеэс хэрэгжүүлж эхлэх ба уурхайг хаахаас 5 жилийн өмнө хаалтын төсөлд тодотгол хийж төлөвлөгөөг нарийвчлан боловсруулан хэрэгжүүлнэ” гэсэн заалт байвал байгаль орчны нь асуудалтай холбон үзэх боломжтой болох юм.</p>
	<p>БОННУ-ний нэмэлт тодотгол үндэслэл, хийх хугацаа, арга аргачлалын хувьд хуульд заалт байхгүй. 5 жил тутамд нэмэлт тодотгол хийнэ гэсэн заалт байхгүй. Зөвхөн журамд төслийн өөрчлөлт, хууль эрх зүйн өөрчлөлтийн үед нэмэлт тодотголыг ерөнхий үнэлгээний чиглэлийн дагуу хийнэ гэж тусгагдсан. БОМТ-г 5 жил тутам шинэчлэнэ гэж байгаа. Өөрөөр хэлбэл нэмэлт тодотгол хийх хэм хэмжээ тодорхойгүй байна. Төсөл хэрэгжүүлэгч нар нэмэлт тодотголыг хийлгэх сонирхол тун бага байгаа. Ерөнхий үнэлгээний чиглэл дүгнэлтийн дагуу тодотгол хийх нь дахин үнэлгээ хийх хэмжээний ажил болж байгаа.</p>	<p>Заалт байхгүй.</p>	<p>Нэмэлт тодотголын талаар хуульд заалт оруулж өгөх хэрэгтэй. Түүнчлэн 5 жил гэдгийг журамд тодорхой зааж өгөх, нэмэлт тодотголын үндсэн чиглэл, аргачлал, журам зэргийг боловсруулж мөрдүүлэх хэрэгтэй байна.</p>

**БАЙГАЛЬ ОРЧИН,
АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ЯАМ**